

**ХУУЛЬ ЗҮЙН БОЛОН ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-38</i>
<i>1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайлан</i>	<i>3-38</i>

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн болон Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 55 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 50.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 50 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Ж.Баясгалан, Л.Мөнхбаатар, Б.Тулга;
Чөлөөтэй: Н.Алтаншагай, С.Амарсайхан, Ц.Баатархүү, Х.Баттулга,
Д.Ганмаа, М.Ганхүлэг, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Цогтбаатар,
Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Б.Бейсен, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн,
Б.Түвшин;

Тасалсан: Б.Баярбаатар, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, С.Одонтуяа.

**Нэг.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн
хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайлан**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хүний Эрхийн Үндэсний комиссын гишүүн Х.Мөнхзул, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Пүрэвдаваа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга А.Адилбиш, мөн албаны Тогтвортой хөгжлийн бодлогын хэлтсийн дарга С.Батцэцэг, Жендэрийн дүн шинжилгээ, мэдээлэл судалгааны хэлтсийн дарга О.Буянаа, Жендэрийн үндэсний шинжээч Б.Долгор, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, Боловсролын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б.Алтансүх, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, мөн яамны Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч М.Цогтбаатар, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбая, референт Б.Баярсайхан, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр нар байлцав.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Д.Энхтуяа, П.Сайнзориг, Л.Энхнасан, О.Саранчулуун, Ц.Сандаг-Очир, Х.Баасанжаргал, Б.Найдалаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хүний Эрхийн Үндэсний комиссын гишүүн Х.Мөнхзул, Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга А.Адилбиш, Жендэрийн үндэсний шинжээч Б.Долгор, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, Боловсролын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б.Алтансүх, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, мөн яамны Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч М.Цогтбаатар, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Б.Хэрлэн, Л.Соронзонболд, Д.Бум-Очир, Д.Рэгдэл, Б.Найдалаа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг хэлэлцэв.

Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 50 минут үргэлжилж, 55 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
11 цаг 50 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БОЛОН ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Сайн байцгаана уу? Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын чуулганы 12 дугаар сарын 30-ны өдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн учраас өнөөдрийн хурлыг нээснийг мэдэгдье. Хуралд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя.

Норовын Алтанхуяг, Отгоншарын Батнайрамдал, Дуламын Бум-Очир, Гонгорын Дамдинням, Бадрахын Найдалаа, Пүрэвжавын Сайнзориг, Мягмардашийн Сарнай, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Мөнхчулууны Энхцэцэг, Аюушийн Ариунзаяа, Энхбаярын Батшугар, Жанчивын Галбадрах, Сархадын Зулпхар, Ухнаагийн Отгонбаяр, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ганбатын Хосбаяр, Лутаагийн Энхнасан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Жудгийн Баярмаа, Амгаланбаатарын Ганбаатар, Тогтмолын Мөнхсайхан, Дүгэрийн Рэгдэл, Отгоны Саранчулуун, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Бадарчийн Хэрлэн, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирж, гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар Засгийн газрын тайлан хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.8-д Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар Засгийн газрын тайланг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2 жил бүр сонсоно гэж заасны дагуу өнөөдрийн тайланг хэлэлцэж байна.

Танилцуулах Бямбацогт сайд ороод ирсэн үү? Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар Засгийн газрын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Жендэрийн

үндэсний хорооны орлогч дарга Сандагийн Бямбацогт сайд хийнэ. Бямбацогт сайдыг урьж байна. Микрофон 4 юм байна.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16.1.7-д Засгийн газар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Улсын Их Хуралд тайлагнахаар заасан.

Тус тайланг 2021 оноос хойш 3 дахь удаагаа Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байна.

Дэлхийн эдийн засгийн форумас жил бүр тооцож буй жендэрийн ялгаатай байдлын үзүүлэлтээр Монгол Улс 2024 онд 145 улсаас 85 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол 2025 онд 148 улсаас 65 дугаарт эрэмбэлэгдэж, 20 байраар урагшиллаа. Тус индексийн дэд индекс болох боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлт тогтвортой, ахиц дэвшлээ хадгалж байгаагийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо 120 дугаар байрнаас 99 хүртэл, ажиллах хүчний оролцоо 43 дугаар байрнаас 20 хүртэл ахиж, ахиц дэвшилтэй гэж үнэлэгдлээ.

Монгол Улс Олон улсын парламентын холбооноос гаргадаг парламент дахь эмэгтэйчүүдийн үзүүлэлтээр дэлхийн 190 улсаас 98 дугаарт эрэмбэлэгдэж, өмнөх жилүүдээс 30 байраар ахисан. Түүнчлэн эмэгтэйчүүд бизнес ба хууль, эрх зүйн орчны үзүүлэлтээр дэлхийн болон бүс нутгийн дунджаас давсан үзүүлэлттэй байна.

Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү 9.18 хувь болж, суурь онтой харьцуулахад 0.33 функтээр буурсан бөгөөд эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ анхаарах, эрт илрүүлэг, оношилгоонд хамрагдах хандлага, дадал нэмэгджээ.

2024 онд Засгийн газрын бүрэлдэхүүнд 3 эмэгтэй сайд байна. Түүнчлэн 1 яамны Төрийн нарийн бичгийн дарга, 6 агентлагийн дарга, яамдын газар, хэлтэст 80, агентлагийн хэлтэс, нэгжид 192 эмэгтэй удирдлага, нутгийн захиргааны байгууллагад улс төрийн томилогдох албан тушаал болох Засаг дарга, Засаг даргын орлогчийн албан тушаалд 4, дүүрэгт 2, сумд 27, хороонд 74 эмэгтэй томилогдон ажиллаж байгаа нь эерэг, бодит үр дүн гарсан байна.

Тайлант хугацааны жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэлхий нийтийн хөгжлийн зорилт үндэсний хууль тогтоомжийн бодлогын хэрэгжилтийг хангах асуудлаар дээрх ололт, амжилт бий болсны зэрэгцээ нийгэм, улс төр, эдийн засаг, төрийн алба зэрэг бүхий л салбарт, бүхий л хүрээнд жендэрийн тэгш бус байдал оршсоор байгааг статистик бас харуулж байгаа.

Тухайлах юм бол, Монгол Улсын нийт хүн амын 51 хувийг эзэлдэг эмэгтэйчүүд нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын 62 хувийг бүрдүүлж, хөдөлмөрийн оролцооны түвшин 2003 онтой харьцуулахад 10.3 хувиар буурч, эрэгтэйчүүдээс 16.2 хувиар бага болсон байна.

Эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс 2023 оны үзүүлэлтээр 21.4 хувь, 24 оны үзүүлэлтээр 19.4 хувиар бага байна. Өрх толгойлсон гэр бүлийн 86 хувь нь эмэгтэйчүүд, 13 хувь нь эрэгтэйчүүд байна. Их, дээд тус сургуульд

суралцагчдын хүйсийн тэнцвэр алдагдаж, бакалаврын түвшинд суралцагчдын 38.6 хувь, сургууль завсардсан болон завсардах магадлалтай хүмүүсийн 72 хувь нь эрэгтэйчүүд байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг улсын дүнгээр 25 нэгжээр буурсан ч нийт гэмт хэрэг зөрчлийн гаралт 2024 оны байдлаар 16, түүнээс дээш насны 10 мянган хүнд ноогдох бүртгэгдсэн гэмт хэрэг улсын дунджаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.6 хувиар, үүнд хүнд гэмт хэрэг 43.5 хувиар өссөн байна.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг улсын дүнгээр 119 нэгжээр, үүнээс хүчиндэх гэмт хэрэг 16.7 хувиар өссөн нь анхаарах асуудал болж байна.

Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг сүүлийн 5 жилд тогтмол өссөн. Нэн ялангуяа 14 насанд хүрээгүй буюу бага насны хүүхэд хохирогч болж байгаа тохиолдол байсаар байна.

Малчдын жендер, хүний эрх, уур амьсгалын өөрчлөлт, түүний жендэрийн эрх, тэгш байдалд нөлөөлөх нөлөөллийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа. Төрийн бодлого, үйл ажиллагаанд өөрсдийн санаа бодлыг тусгуулах, хэрэгцээ шаардлагаа илэрхийлэх мэдлэг, хандлага дадал сул зэрэг анхаарах асуудлууд байсаар байна.

Иймд тус тайланг Монгол Улсын Их Хурлаас Засгийн газарт өгсөн зөвлөмж, чиглэл, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын холбогдох илтгэлд дурдсан анхаарах асуудлыг харгалзан үндсэн 4 бүлэг асуудлаар боловсруулан танилцуулж байна. Үүнд:

1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт 70 хувь, хэрэгжилт үр дүнтэй.

2-т, Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төлөвлөлтийн талаарх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт 70 хувь, хэрэгжилт үр дүнтэй.

3.Хөдөөгийн охид, эмэгтэйчүүд, залуу малчдын жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт 30 хувь, хэрэгжилт үр дүнгүй.

4.Жендэрийн статистик, дүн шинжилгээ, мэдээлэл, судалгааны чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт 50 хувь, үр дүн хүлээгдэж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 55 хувь болж хэрэгжилтэд зарим ахиц, дэвшил өмнөх тайлантай харьцуулахад гарсан байна.

Цаашид үр дүнд суурилсан төлөвлөлт, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх туршлага, чадавхыг бүх түвшинд нэмэгдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг ахиулахад анхаарч ажиллах талаар хуулиар үүрэг хүлээгч бүх талуудад чиглэл, зөвлөмж өгч ажиллалаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад бүх талын оролцоо, манлайлал, тогтвортой байдлыг эрхэмлэн Монгол Улсын Засгийн газраас дараах хөгжлийн стратегийг тууштай баримтлан ажиллах болно.

1. Жендэрийн хариуцлагатай бодлого, төлөвлөлтийг үндэсний салбарын, орон нутгийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээнд үр дүнтэй, тогтвортой нэгдэхүйц эрх зүй, бодлогын орчны дэмжлэгийг ахиулах.

2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны тогтвортой байдлыг хадгалах, жендэрийн мэргэжилтэн, үндэсний шинжээчдийн чадавхыг бэхжүүлж, мэдлэг, туршлага, сургамж дээр суурилсан үр дүнтэй мэдлэгийн болон хамтын ажиллагааны платформыг өргөжүүлэх.

3. Уур амьсгалын өөрчлөлт, технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн шилжилт, хүн амын төвлөрөл зэрэг шинэ эрсдэл, сорилтуудыг даван туулахад жендэрийн бодлогын чиглэл, арга хэмжээг илүү үр нөлөөтэйгөөр төлөвлөх. Тухайлбал, хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн байдал, малчин залуу гэр бүлд үүсэж буй жендэрийн тэгш бус байдлыг арилгах, орон нутгийн иргэд, нутагтаа ажилтай, орлоготой жендэрт суурилсан хүчирхийллээс ангид эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, төлөвлөлтийг батлан хэрэгжүүлэх.

4. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг анхаарах зэрэг болно.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг та бүхэндээ танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Найдалаа: Танилцуулга хийсэн Бямбацогт сайдад баярлалаа. Ажлын хэсгийн хуралд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Батхүү дарга байгаа юм уу? Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга А.Адилбиш, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Туяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Отгонбилэг, Боловсролын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Алтансүх, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Золбоо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Цогтбаатар, Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны Тогтвортой хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Батцэцэг, Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны Жендэрийн дүн шинжилгээ, мэдээлэл судалгааны хэлтсийн дарга Буянаа, Жендэрийн үндэсний шинжээч Долгор. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Сандаг-Очир гишүүнээр, Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүнийг микрофонд урья.

А.Ариунзаяа: Би Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны дарга, Жендэрийн үндэсний хорооноос асуулт асуухгүй. Би Бямбацогт сайдаас асуулт асуух гэсэн юм. Тэгээд маш энгийн асуулт. Энэ яагаад ер нь энэ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталж байсан юм бол? Ер нь яагаад заавал ч үгүй энэ эмэгтэйчүүдийг улс төрийн албан тушаалд томилох ийм хуулийн квот тавьж өгсөн юм бол оо? Ер нь эмэгтэйчүүд энэ тодорхой албан тушаалуудад, улс төрийн албан тушаалуудад яагаад ийм хэрэгцээтэй байдаг юм бол гэдгийг таны нүдээр яг юу гэж ойлгож байгаа вэ? Эмэгтэйчүүд энэ квотоор зайлшгүй ингэж оруулах нь зөв юм уу, үгүй юм уу гэдгийг Хэрэг эрхлэхийн сайдын хувьд юу гэж бодож байна вэ?

Б.Найдалаа: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: 2011 онд тийм ээ. 2011 онд энэ Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг батлахад манай тухайн үед Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хороон дарга асан Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн бас онцгой анхаарч энэ хуулийг батлуулсан юм.

Ингэхдээ бас хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах, энэ тодорхой ялангуяа удирдах албан тушаалд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна. Ер нь Монголчууд бас эрт дээр үеэсээ уламжлалаар бас эцгийн эрхт ёс ноёлох давамгайлсан ийм хандлагатай учраас төрийн албанд, энэ удирдах албан тушаалд голцуу эрчүүд томилогддог, эрчүүд бас илүү ажиллана гэж үздэг энэ хандлагыг бас өөрчилье гэдэг үүднээс энэ хуулийг батлуулж, энэ хүрээндээ албан тушаалд жендэрийн тэгш байдлыг хангах удирдах албан тушаалд энэ зорилгоор анх эмэгтэйчүүдийн квот улс төрийн албан тушаал болон төрийн удирдах албан тушаалаас тодорхой хэмжээгээр орж ирсэн.

Энэ дээр гэхдээ жендэрийн тэгш байдал гэхээр зөвхөн эмэгтэй, эрэгтэй гээд ялгавартай хандах аль нэгийг онцгой анхаарах гэсэн асуудал биш. Бүхий л түвшинд сая бас энэ танилцуулга дээр гарсан энэ сургуульд сурч байгаа бакалаврын түвшний боловсрол эзэмшиж байгаа оюутнуудын дийлэнх нь эмэгтэйчүүд болчихсон байна. Эрэгтэйчүүддээ анхаарах ёстой. Эрүүл мэндийн салбар, багш боловсролын салбарт ажиллаж байгаа албан тушаалтнуудын дийлэнх нь бас эмэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүдийн бас эзлэх хувийг нэмэгдүүлэх гээд энэ асуудал бодлогын хувьд цогцоороо бас ингээд хангагдаж явах ёстой.

Сая бас тайланд гарсан эмэгтэйчүүдийн энэ улс төрд оролцох оролцоо, төрийн удирдах албан тушаалд албан тушаал хаших хандлага сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа. Үүгээрээ ч дэлхийн 145 улсаас 85-д эрэмбэлэгдэж байсан бол 148 улсаас 65-д эрэмбэлэгдэж 20 байраар урагшилсан нь бас энэ 2011 онд бас энэ баталсан Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн энэ бас бодлогын үр дүн ингээд гарч байгаа.

2024 оны Улсын Их Хурлын сонгуулиар ч гэсэн бас нэлээн томоохон ахиц гаргасан. Улсын Их Хурал бас түүхэнд байхгүй олон бас эмэгтэй гишүүд бас төрд ард түмнийг төлөөлж бас гишүүн болсон нь бас энэ бодлого маань Монгол Улсад харьцангуй бас амжилттай хэрэгжиж байгааг илэрхийлж байгаа юм.../минут дуусав./

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулж асууна.

А.Ариунзаяа: Хууль 11 онд батлагдсан. Яагаад ер нь эмэгтэйчүүд улс төрийн албан тушаалд томилогдох ёстой юм бэ, хуулийн хэрэгжилтийг ер нь хангах ёстой юу үгүй юү гэдэг үндсэн асуулт байсан юм. Яагаад гэвэл Засгийн газар энэ хуулийг огт хэрэгжүүлэхгүй байгаа. Тэгээд Засгийн газраас жишээлбэл Засгийн газар өөрөө 21 сайдтай шүү дээ. 2-хон эмэгтэй сайдтай. 10 хувь ч хүрэхгүй. Гэтэл 11 онд батлагдсан хуулиар 15 хувь, хамгийн багадаа 15 хувь эмэгтэйчүүд байх ёстой байхгүй юу. Уг нь яах вэ 15 хувь нь эрэгтэйчүүд байгаа. Тэрнээсээ дээш эмэгтэйчүүд байж болно хүйсийн аль нэг байдал гэдэг агуулгаар байна шүү дээ ер нь.

Тэгэхээр ер нь Засгийн газар өөрөө энэ хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа нь маш ноцтой байна. Үүнийг би байнга хэлдэг. Түүнээсээ зөвхөн сайд нарыг ч авч үзэхгүй энэ дотор бас Төрийн нарийн бичгийн дарга нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, дүүргийн Засаг дарга нар, сумын Засаг дарга нар бүхий л тухайн агентлагийн дарга нар, яам хэлтсийн дарга нар гэх зэрэг бүхий л албан тушаал дээр квот.../минут дуусав./

Б.Найдалаа: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Засгийн газрын түвшинд бас энэ жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал жоохон учир дутагдалтай байгаа нь үнэн. Тантай санал нэг байна. Өнөөдөр Засгийн газарт 2 эмэгтэй сайд байгаа байх тийм ээ. 10 хувьтай. Уул нь 15 хувь хангах юм бол 3 болох ёстой. Тэгээд энэ дээр бас тухайн Ерөнхий сайдын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх учраас Ерөнхий сайд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бас Ерөнхий сайд л анхаарах байх. Энд бол тэр бүрэн эрх рүү халдаж хэлмээргүй байна. Харин сая бас дэд сайд нар томилогдоход нэлээн бас 4 эмэгтэй дэд сайд томилогдсон. Энэ хүрээндээ бас үндсэндээ бас хангагдаж байгаа. Цаашдаа бид бүхэн бас төрийн захиргааны албан тушаалууд дээр бас аль болох бас энэ жендэрийн эрх тэгш байдлыг хангах тал дээр бас анхаарах ёстой тантай санал нэг байна.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн нэмж тодруулна.

А.Ариунзаяа: Хэдийгээр Ерөнхий сайд ч гэсэн хууль хууль доор бид бүгдээрээ л ижил, тэгш хуулийг хэрэгжүүлэх үүргийг хүлээж байх ёстой. Ийм учраас хэдийгээр Ерөнхий сайдын бүрэн эрх гэж байгаа ч гэсэн Ерөнхий сайд маань өөрөө хуулиа хэрэгжүүлдэг байх үүрэгтэй шүү гэдгийг бас энэ ташрамд хэлмээр байна.

Тэгэхээр хэн нэгэн хүн өөрөө сайд болох гээд байна гэдэг байдлаар албаар энэ Жендэрийн хуулийг үгүйсгэдэг хэсэг бүлэг хүмүүс байдаг. Энд огт зүгээр энэ үг хэлж байгаа хүн сайд болох гээд байгаа асуудал огтоос биш. Зүгээр л хаа байсан 11 онд батлагдсан хуулийг хэрэгжүүлдэг байгаасай. 11 онд 15 хувь гэж байсан чинь одоо хүртэл уг нь бас нэмэгдчихмээр л байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бас Хэрэг эрхлэхийн сайдын хувьд анхаарч өгөөрэй гэж хэлмээр байна.

Сайдын хувьд та анхаарч чадахгүй юм гэхэд ядаж Хэрэг эрхлэх бусад аймаг, дүүргийн хэмжээнд, бусад яамдын хэмжээнд томилогдож байгаа энэ хүмүүс

дээр энэ хуулиа мөрдөөсэй, мөрдөх тал дээр нь та анхаарч өгөөрэй гэж хүсмээр байна. Яагаад гэвэл хуулийг баталж байгаа бол.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Үг хэллээ. Энхтуяа гишүүн асуулт асууна.

Д.Энхтуяа: Та бүхэндээ энэ бага үдийн мэнд хүргэе. Сая Бямбацогт сайдын гаргасан энэ бидэнд танилцуулсан тайлангаар бас улс төрийн түвшинд, шийдвэр гаргах түвшинд энэ жендэрийн тэгш эрх байдлыг хангах харьцангуй бас ахиц дэвшил гарсан байна гэсэн ийм тайлан, мэдээллийг сонслоо.

Миний хувьд ер нь сүүлийн үед манай дээр асрахуй эдийн засаг гэж нэлээн бас яригдаж байна. Тэгээд энэ маш чухал юм. Тэгэхээр өнөөдөр яг гэрээр асаргаа, сувилгаа хийж байгаа энэ хүмүүсийн дийлэнх нь 52 хувь байдаг билүү дээ, хувь байгаа эмэгтэйчүүд байна. Тэгэхээр энэ эмэгтэйчүүдийн энэ асрахуйн эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг өнөөдөр Монгол Улс хэр зэрэг бодитойгоор үнэлж байгаа юм бэ? Асрахуйн эдийн засаг гээд ингээд яриад байгаа боловч яг бодитой ахиц, дэвшил гараагүй байна гэж ингэж би бас харж байна.

Тэгэхээр асрахуйн эдийн засгийг үнэлэхгүй байна. Эмэгтэйчүүдийн энэ хөдөлмөрийг цалингүй гэж хэлж болно. Мөн нийгмийн хамгааллыг баталгаажуулж чадаагүй байна гэх мэтчилэн бас энэ дээр бас эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн асуудал яригдах байх, яригдаж байгаа. Тэгэхээр яг энэ дээр хийсэн судалгаа, тайлан байгаа юу? Асрахуй эдийн засаг энэ гэрээр асаргаа хийж байгаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг үнэлэх талаар цаашид баримтлах бодлого ямар нэгэн судалгаа шийдвэрийн түвшинд гарсан байгаа болов уу? Энэ дээр нийгмийн хамгааллынхан ирсэн байна. Энэ дээр бас хариулт аваад тэгээд тодруулъя.

Б.Найдалаа: Хариултыг микрофон хэд вэ? Микрофон 3.

Б.Отгонбилэг: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны яам Отгонбилэг. Тэгэхээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа 83 мянга орчим иргэн байдаг. Эдгээр иргэдийн бас 60 орчим хувь нь эмэгтэйчүүд байгаа. Тэгэхээр ер нь асрахуй эдийн засаг буюу ингээд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн асарч байгаа хүмүүсийг аль болох энэ асаргааны энэ үйлчилгээнээс нь бас багасгах, дэмжих зорилгоор асаргааны хувилбарт үйлчилгээ гэсэн энэ үйлчилгээнүүдийг Ахмад настны тухай хуульд оруулаад хэрэгжүүлж явж байна. Өдрөөр асрах, гэр бүлд нь очиж асрах, тусгай байранд түр асрах зэрэг ийм олон төрлийн үйлчилгээг нэвтрүүлж эхэлж байгаа. Цаашдаа энийг илүү анхаарч аль болох мэргэжлийн байгууллагаар асруулж, тухайн гэр бүлийн эмэгтэйчүүдийг ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх энэ зохицуулалтуудыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад хууль дээр бас тусгаад явж байгаа юм. Тэгэхээр цаашдаа энэ дээр анхаарч ажиллах болно.

Б.Найдалаа: Бямбацогт сайд нэмж хариулаад.

С.Бямбацогт: Энд дээр бас хүүхдийн мөнгө энэ бас асрахуй эдийн засагт тодорхой хувь нэмрээ оруулдаг. Ялангуяа цалинтай ээж хөтөлбөр. Нөгөө 3 хүртэл насны хүүхдээ асарч, өсгөж хүмүүжүүлж байгаа ээж нарт бас сар болгон бас урамшуулал өгдөг болсон. Энэ бас нэлээн том хувь нэмрээ оруулж байгаа. Ер нь цаашдаа бид нар бас энэ асрахуй эдийн засагт бас зөвхөн төр үүрэгтэй, төр оролцдог, төрийн төсвийн хөрөнгөөр хийдэг биш хувийн хэвшлийн асрамжийн

газрууд байгуулж өндөр настай иргэдийг, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах энэ асрамж, сувиллын газар байгуулах тал дээр бас бодлогын дэмжүүлэх үзүүлэх тал дээр Засгийн газар бас анхаарч ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Энхтуяа гишүүн тодруулж асууна.

Д.Энхтуяа: Ер нь яг Ахмад настны тухай хууль саяын энэ 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн энэ хуульд хувилбар асрах үйлчилгээний асуудлаар бас нарийн зүйл, заалтууд орсон байдаг. Харамсалтай нь бас хэрэгжилт нь дөнгөж хэрэгжээд явж байгаа. Одоо бол дүгнэх бас боломжгүй байгаа. Энийг сайн мэдэж байгаа.

Гэхдээ өнөөдөр би бас яг ингээд асрахуйг гэртээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ахмад настнаа асарсан ийм хүмүүс эргээд бас нийгмийн хөдөлмөрийн зах зээл дээр гарч ажиллах энэ боломж нь ч гэдэг юм уу бодит байдал дээр маш муу, хангалтгүй байдаг. Тийм учраас магадгүй энэ асаргаа, сувилгаа хийсэн энэ хүмүүсийг цаашид яг энэ чиглэлээрээ ажиллах энэ чиглэлийг бас хийх ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ хүмүүс чинь жишээлбэл багш мэргэжилтэй хүн байлаа гэхэд 3 жил гэртээ ямар нэгэн өвчтэй, зовлонтой хүнээ асарчихсан хүн эргээд багшийн ажил хийх бас боломжгүй яг бодит амьдрал дээр. Тэгэхээр магадгүй энэ хүмүүсийг эргээд асрахуйн чиглэлээр нь ажиллуулах, бүртгэлжүүлэх ч байдаг юм уу, үнэмлэхжүүлэх.../минут дуусав./

Б.Найдалаа: Энхтуяа гишүүн яах уу нэмж минутаа нэгмөсөн аваад тодруулах уу дараа нь? Энхтуяа гишүүн минутыг нь.

Д.Энхтуяа: Энэ дээр энэ журамдаа бас нарийн зүйл, заалт оруулаад энэ хүмүүсийг цаашид хөдөлмөр эрхлэхийн бололцоогоор хангах ийм л асуудал байгаа. Тэгээд сая бас Отгонбилэг дарга хэлж байна 60 орчим хувь нь эмэгтэйчүүд. Тэгэхээр эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг үнэлэх ийм зүйл, заалт оруулах хэрэгтэй. Сая энэ Бямбацогт сайдын хэлснээр Засгийн газар дэмжиж ажиллах юм байна. Миний хувьд энэ асрахуйн эдийн засгаар хувийн хэвшлийг яаж оролцуулах талаар бас анхдагч хуулийн төслөө бас боловсруулаад Засгийн газарт бас хүргүүлсэн байгаа. Тэгээд энэ дээр бас хамтарч ажиллах байх гэж найдаж байна.

Б.Найдалаа: Асуулт уу? Үг хэлчихлээ. Баярлалаа. Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Энэ жендэрийн эрх тэгш байдал бас алдагдах нь ер нь зүгээр нийгэмд тийм үл үзэгдэгч тийм гар үүсэж байдаг л даа. Тэгээд бид хэдийн бас энэ асуудлыг ярихдаа тийм уламжлалт диалоги яваад байна. Эмэгтэйчүүдийг улс төрийн оролцоог хангах, эмэгтэйчүүдийн бас үр хүүхдээ асрах цаг хугацаа. Энэ бас ингээд шийдэгдэхгүй яваад байгаа нь энэ диалогиос гарахгүй. Энэ хүрээндээ л бид асуудлыг бас ойлголт бас тунаж үлдэх гээд байгаа шүү. Тэгэхээр энийг бас би жоохон бас анхаараач гэж бас хүсэж байгаа юм.

Сая Бямбацогт сайдын танилцуулга, мэдээлэл дээр их, дээд сургуульд суралцагчдын дийлэнх нь охид, бүсгүйчүүд байна. Энэ бол сайн үзүүлэлт. Ер нь бас ЕБС-ийн завсардалт дээр завсардах магадлалтай нь дандаа эрчүүд байна. 72 хувьтай бүр эрсдэл байна. Тэгэхээр энэ нөхцөл байдал цаашдаа эдийн засаг буюу

ажиллах хүчин дээр бас томоохон нөлөө үзүүлнэ. Энэний үр дагаврын судалгаа, янз бүрийн юм хийгдэж байгаа зүйл байна уу?

Дээрээс нь яг энэ хандлагаас гэдэг юм уу энэ явж байгаа үзэгдлээс болоод ганц бие залуучууд, малчид хөдөө орон нутгаар асар их боллоо. Энийгээ дагаад маш их хэмжээний сөрөг үзэгдлүүд бий болж байна. Хүн ам зүйн бодлого дээр, хүн амын өсөлт дээр, эдийн засгийн өрхийн бүтээмж дээр хүртэл нөлөөллүүд байна. Тэгэхээр бид хэд ер нь цаашдаа энэ аавуудын тухай, энэ эрчүүд, хөвгүүдийн тухай бас энэ асуудал дээр энэ одоо яг жендэр гэхээр зөвхөн улс төрийн албан тушаалууд томилгооны асуудал биш. Энэ нийгмийн яг суурь анхан шатны тэр яг хүн, хүний тэр амьдралын хэмнэл дээр бусад асуудлууд дээр юу болж байна аа? Энэний сөрөг үр дагавар дээр судалгаа хийж байгаа, энэ рүү анхаарч байгаа ямар юм байна гэдэг зүйл 1 дүгээрт асууя.

2 дугаарт, Ер нь зүгээр эмэгтэйчүүдийн давуу тал тэвчээртэй, үнэнч шударга, бас урваж шарвадаггүй хүмүүс байдаг ерөнхийдөө. Энэ үзэгдлээрээ уг нь авлигатай тэмцэх бас хамгийн чухал алхам бол эмэгтэйчүүдийг бас энэ аж ахуйн буюу шийдвэр гаргах ажил дээр түлхүү байх нь зөв. Тэгэхээр өнөөдөр бас Монголд байгаа энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын удирдлагууд дээр яг энэ жендэрийн эрх тэгш байдлын асуудал ер нь ямархуу багцаатай явж байна? Эмэгтэйчүүд ер нь энэ ТӨК-удыг ер нь тэргүүлж байгаа хувь, хэмжээ хэр байна? Ийм зүйлүүдийг бас хувь харьцаан дээр хэлж өгөөч. Би бас Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн бас боловсруулах ажлын хэсэгт байгаа учраас бас энэ их чухал байх. Тэгэхээр илүү их эмэгтэйчүүд бизнесийг бас мөн чанараар нь бараг хэрэглэгч рүүгээ, хүн рүүгээ чиглүүлээд илүү их юу гэдэг юм үнэнч, шударгаар бас хийдэг юм болов уу зүгээр бас ерөнхий ийм тойм судалгаанууд ч хүртэл байна. Тэгэхээр манайх энийг төрийн болон орон нутгийн өмчийн бодлого дээр энэний менежментийг авч явах боловсон хүчний бэлдэх бодлого дээр ер нь ямархуу байдлаар хандаж байгаа юм бэ? Тэгэхдээ эрэгтэй, эмэгтэй 2 хүмүүсийн энэ дундаж.../минут дуусав./

Б.Найдалаа: Хариулт Бямбацогт сайд нэмээд хариулаарай.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн бас их чухал асуудал хөндөж байна. Бид нар 11 онд хуультай болсон ч гэсэн одоо болтол бас яг тодорхой болгоод шийдэж чадаагүй, үр дүн гарахгүй байгаа 2 асуудлыг та хөндлөө. Энэ бол эмэгтэйчүүдийн улс төрд оролцох оролцоо, төрийн байгууллагын бас удирдах түвшинд ажиллах ажиллах нөлөөлөл нэмэгдсэн. Энэ бол сайн үр дүн.

Нөгөө талдаа үр дүн гарахгүй байгаа 2 асуудал бол таны саяын ярьж байгаа уламжлалт хандлага л даа. Энийг л өөрчлөх ёстой болчихоод байгаа юм.

Хөдөөд малчид маань хүүхдүүдээ энэ эр юм яах вэ тэгээд амиа тээчих болов уу, амьдраад явчих байлгүй. Энэ эмэгтэй хүүхдээ л нэг сургууль соёлын бараа харуулчихвал энэ цаашаагаа тэгээд амьдралд нь хэрэгтэй байх, эрчүүд нь яах вэ гэдэг. Ингэсээр байгаад одоо их, дээд сургуульд үндсэндээ олон жил эмэгтэй хүүхдүүд нь явж сурдаг. Хот хүрээ яваад тэндээ суурьшихдаг. Хөдөөд малчин эмэгтэйчүүд байхгүй болсон. Гэр бүл болох, хамт амьдрах эмэгтэй байхгүй учраас малчин эрчүүд маань тэгээд л ганц биеэрээ амьдарч байгаа.

Энэ бол энэ цаг үед бидний шийдэх ёстой маш том тулгамдсан асуудал болсон. Энийг шийдэх тал дээр энэ манай Жендэрийн үндэсний хороо энэ хууль

маань бас амжилтгүй байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам маань бас энэ тал дээр бас хангалтгүй ажиллаж байна. Энийг бид нар бас энэ тайлан дээр бас нэлээн онцгой дурдаад энэ дээр Засгийн газар ийм ажил хий, хариуцсан яам нь ийм ажил хий, Жөндөрийн үндэсний хороо ингэж анхаар гээд маш тодорхой чиглэл, удирдамж гаргаад өгөх хэрэгтэй байх. Ингэхгүй бол яг үнэндээ энэ нэг тулгамдсан асуудал болчихсон.

Нөгөө талдаа бас өрх толгойлдог, өрх гэрийн эзэн нь эрчүүд байдаг. Түүнтэй адилхан байгууллага эрэгтэй хүн удирдах юм бол их сайн удирдана. Эрэгтэй хүнд л даатгая, эрэгтэй хүнд л найдъя гээд энэ ТӨК-удын удирдлагуудаас авхуулаад хувийн хэвшлийнхэн ч гэсэн ихэнх захирлууд нь эмэгтэйчүүд. Гэхдээ хувийн хэвшилд нэлээн эрэгтэйчүүд. Эмэгтэй захирлууд бас байр суурь нэмэгдэж байгаа.

Гэтэл хамгийн итгэлтэй, хамгийн шударга, хамгийн ажил хэрэгч, хамгийн хариуцлагатай хүмүүс эмэгтэйчүүд маань байдаг. Гэтэл яг л нөгөө толгой дээр нь тавих болохоороо эрэгтэй хүнд илүү итгэвэл, найдвал дээр байх гэдэг хандлага өнөөдөр бас төрийн албанд байна. Энэ ТӨК-уд дээр байгаад байгаа. Энийг хэрхэн яаж илүү авлигад өртөхгүй, илүү шударга, илүү хариуцлагатай энэ бас эмэгтэй удирдагч нарыг гаргаж ирэх вэ гэдэг дээр бид нар бас бас тодорхой хэмжээний чиглэл өгөөд юм уу, энэ дээр ямархуу шийдэл гаргаж болох вэ анхаарах ёстой байх. Тэгээд энэ дээр тантай бас санал нэг байна.

Нэмээд судалгаанууд хийж байгаа. Тэгээд судалгаа хийгээд байдаг. Баахан төсөв мөнгө зараад, үрээд байдаг, төсөл хэрэгжээд байдаг эцэст нь ингээд л байж байгаа үр дүн ийм л байгаад байгаа байхгүй юу. Тийм болохоор бас бодитой үр дүн гарах ёстой. Яг бодитой хэдэн төгрөгийн зардал гаргасан юм, ямар үр дүн гаргасан юм, энэ бодлогоо олж харж чадсан юм уу? Энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгаалалынхан хариулт өгчих.

Б.Найдалаа: Микрофон 3.

Ю.Отгонбилэг: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Отгонбилэг.

Тэгэхээр Монгол Улсад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 9.2 байгаа нь бусад улстай жишихэд нэлээд өндөр байгаа. Ийм учраас 2024 оны 71 дүгээр Ерөнхий сайдын захирамжаар эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Энэ төлөвлөгөөнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг бүхий л салбарт бас хийх ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоо илүү сайн байгаа. 57.5 хувь нь эмэгтэйчүүд энэ хөдөлмөрт бэлтгэх, мөн санхүүгийн дэмжлэг болон бусад үйл ажиллагаанд илүү хамрагдаж байгаа юм.

Цаашдаа яг энэ хөдөөгийн эмэгтэйчүүд болон энэ эрэгтэйчүүдийн дундаж насыг бууруулах дээр хууль тогтоомжийн хувьд ч гэсэн, мөн хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд ч гэсэн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа юм.

Б.Найдалаа: Сайнзориг гишүүн тодруулчаад. Хариулах уу? Микрофон 2.

Б.Алтансүх: Та бүгдийн энэ өдрийн мэндийг эрье. Боловсролын яам Алтансүх. Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д насан туршийн суралцахуйн төв бичиг, үсэг болон ерөнхий боловсрол эзэмшин, нөхөн эзэмшүүлэх сургалтыг үнэ

төлбөргүй зохион байгуулдаг. 2025-аас 26 оны хичээлийн жилд сургууль завсардсан, эсвэл ерөнхий боловсрол эзэмшиж чадаагүй нийт 4 мянга гаруй иргэнд нөхөн боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулж байна.

Үүнээс малчин 1731 хүүхэд, залуучуудаас бага боловсролд 98, суурь боловсролд 528, бүрэн дунд боловсролд 1105 суралцагч хамрагдаж байна.

Б.Найдалаа: Сайнзориг гишүүн тодруулж асууна.

П.Сайнзориг: Тэгээд бид нар бас өмнөх зүйлүүд шийдэгдээгүй байгаа. Тэр уламжлалт диалогиос гадна бас эрчүүд рүүгээ, энэ хөвгүүд рүүгээ чиглэсэн юмнуудыг бас анхаарах зайлшгүй шаардлага байна. Эрчүүдийн амиа хорлолт маш өндөр байна. Эрчүүдийн өвчлөл маш өндөр байна. Эрчүүдийн сэтгэл гутрал маш өндөр байна. Ийм зүйлүүд байхад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн бас тэгш ойлголцол гарахгүй. Энэ дээр дандаа хүчирхийллийн аргууд товойж гарч ирнэ.

Тийм ч учраас гэмт хэрэг зөрчлийн асуудал ч гэсэн суурь шалтгаан тэр сэтгэл зүйн буюу анхны тэгш боломжийг бас тэр анхдагч тэр харилцаанууд дээр байхгүй болж байгаа учраас энэ зүйлүүд чинь бас цаашдаа илүү их өөр түвшний гар-ууд гарна шүү гэдэг зүйлийг би бас энд анхааруулж хэлмээр байна. Тэгээд Жендэрийн эрх тэгш байдлын энэ тайланг уг нь сонсоод өнгөрөх биш тодорхой шийдвэр гаргадаг байх ёстой юм. Хүний эрхийн Үндэсний Комиссын тайланг бас бас яг ингэдэг байсан юм. Энийг нь хуулийг нь өөрчлөөд Улсын Их Хурлаар сонсдог болсон. Зөвхөн Байнгын хорооны, 2 Байнгын хорооны сонсдог биш ингээд Улсын Их Хурлаар шийддэг ийм зүйл рүү рүү орсон.../минут дуусав./

Б.Найдалаа: Нэмж 1 минут.

П.Сайнзориг: Ер нь төрийн түвшин, улс төрийн түвшиндээ аль болохоор чармайж байгаа. 23 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөс эхлээд энийг дагаж гарсан Сонгуулийн хууль, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль зэрэг маш олон хуулиуд дээр жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах зарчмууд орж бас маш олон эмэгтэйчүүд бас энэ leadership хийх бололцоогоо харуулж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Харин бусад зүйлүүд дээр анхаармаар байна. Тэгээд энэ эрчүүдийн асуудал орхигдсоноороо угаасаа илүү л том асуудал үүснэ. Энэ архидалт, эргээд энэ хүчирхийлэл ч байдаг юм уу тэгэхээр энэ зүйл рүүгээ бас цаашдаа анхаарах цаг болсон байна шүү. Хүн ам зүйн бодлогын асуудлыг Засгийн газрын түвшинд яг тодорхой мэргэжлийн газар гэдэг юм уу Аубакир сайдын яаманд ийм газар байхгүй бараг 1, 2 мэргэжилтэн байгаа. Монгол Улсад хүн ам зүйн бодлогоо орхино гэдэг бол жендэрийн эрх тэгш байдлын асуудал дээр бодлого гаргана гэдэг байхгүй болчихсон юм шүү. Жендэрийн энэ эрх тэгш байдлын байгууллага маань ерөнхийдөө соён гэгээрүүлэх чиглэлдээ ажиллаад байгаа учраас суурь судалгаа, бодлогын асуудлууд орхигдсон. Энэнээсээ болоод.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Үг хэллээ. Энхнасан гишүүн. Асуулт, тэгье энэ дээр би бас яг тодруулаад Сайнзориг гишүүн дээр хэлчихье. Яг асуулт давхцаад миний хувьд бас. Тэр орон нутгийн тэр саяын тэр залуучуудын гэр бүлийн асуудал, тэгш бус байдал үнэхээр ноцтой, жендэрийн асуудал биш Монголын нийгмийн ноцтой асуудал байгаа. Энэ дээр яамны зүгээс, Засгийн газрын зүгээс яг ямар

бодлого зүгээр жендэрийн хэмжээнд хармааргүй байгаад байгаа байхгүй юу. Яг ямар бодлого байгаа юу байхгүй юу гэдэг дээр хариулж өгөөч. Зөв асуулт.

Микрофон. Энийг дараа нь Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас. Микрофон 1.

Ю.Отгонбилэг: Сайнзориг гишүүн их чухал асуудал хөндлөө. Тэгэхээр эрэгтэйчүүдийн жендэрийн асуудал өнөөдөр бид нарын анхаарах ёстой бас асуудал байгаа. Ялангуяа бид нарын нүдэнд харагдаж байгаа байдал гэхээрээ зөвхөн эрүүл мэнд, боловсролын асуудал харагдаад байна. Тэгтэл үүний цаана амиа хорлолт, жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэж байгаа хүмүүсийн ихэнх нь эрэгтэйчүүд гээд. Тэгээд энэ дээр авч байгаа бодлого, арга хэмжээ нь гээд бид нар нөгөө хүчирхийлэл үйлдэгч жишээлбэл үйлдэгчийг ингээд хориод цагдаад л улам үйлдэлтэй нь тэмцээд л үзэл, хандлага, ухамсар руу нь ч чиглэсэн энэ архи ууж байгаа, мансууруулах бодис хэрэглэж байгаа энэ хүмүүсийг хүмүүст үйлчлэх тусламж, үйлчилгээний асуудал эд нар Монгол Улсад өнөөдөр байхгүй байна гэж хэлэхээр байна. Тэгэхээр яг энэ Хүн ам зүйн.../минут дуусав./

Б.Найдалаа: Яамнаас хариулах уу? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас. Микрофон 3 уу? Микрофон 3.

М.Цогтбаатар: Өдрийн мэнд хүргэе. Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Хүн ам зүйн бодлого дээр та бүгдийн ярьж байгаатай санал нэг байна. Манай Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сая өнгөрсөн 7 сард бас Засгийн газрын бүтцээр өөрчлөлт орж Хүн амын асуудал хариуцсан хэлтэс бас татан буугдсан. Одоогоор Гэр бүл, хүн амын асуудал хариуцсан 1 л мэргэжилтэн, ахлах шинжээч ажиллаж байна. Тэгэхээр энэ хүн ам зүйн асуудал, бодлого, судалгаа гаргах нь хамгийн чухал суурь асуудал гэдэг нь та бүхэн хөндөж байгаад бас баяртай байна. Өмнө нь жендэрийн асуудлаар жендэрийн нүцгэн үнэн гээд судалгаа 17 онд хийгдэж байсан бол сая 2024 онд 25 оны эхээр бид нар бас гэр бүлийн хэв шинжийн судалгааг бас хийсэн. Тэгэхээр энэний үр дүнд гэр бүлийн салалт, гэр бүлийн хүчирхийллийн маргаан.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Микрофон 3.

М.Цогтбаатар: Жендэрийн хүчирхийлэл юутай холбоотой вэ гэдэг асуудал дээр бас нэлээн олон тоо баримт гарч ирсэн. Энэ дээр гэр бүл салалт нь 30 гаруй хувь нь үзэл бодлын зөрүүтэй байдал буюу та бүгдийн өнөөдөр хөндөж байгаа боловсролын ялгаатай байдал, цаашдаа үзэл бодлын зөрүүтэй байдал дээр нь санхүүгийн бэрхшээлтэй байдал, энэ архидалт гэх мэт энэ сэдвүүд одоо гарч ирсэн. Энэ бол өмнөх судалгаанууд дээр ч гэсэн мөн адил 30 хувь, тэрнээс дээш хувьтай бас гарч ирж байсан энэ судалгаанууд энэ жилийн хувьд бас дахин давтагдсан.

Тэгэхээр энэ дээр бид бүхэн энэ хүн ам зүйн бодлогыг ахиж гаргах, Монгол Улс бол хүн амын тухай бодлого 7 чиглэлээр энэ хүний хөгжлийн хөтөлбөр, нийгмийн хөгжлийн хөтөлбөр гээд энэ томоохон хөгжлийн хөт.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Микрофон 3-ыг нээгээрэй. Таны албан тушаал юу билээ?

М.Цогтбаатар: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны яам Гэр бүлийн бодлогын газрын Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч.

Б.Найдалаа: Яамнаас өөр арай бодлогын түвшний дарга байхгүй билүү? Энд гишүүний асуугаад байгаа нь энэ байна л даа. Та тэгвэл урагшаа сууж байгаад хариулах уу?

Энэ саяын тэр хүн ам зүйн асуудал бол өчигдөр бий болоогүй, 2 жилийн өмнө ч бий болоогүй, маш олон жил ингээд ужгираад явж байгаа байхгүй юу. Тэгээд ийм асуудал нь ужгираад явж байхад яаман дээр эрх биш ингэнэ дээ тэгнэ дээ гэсэн шийдэл биш юм гэхэд бодлого юм байгаа байлгүй дээ. Яг энэ дээр яг яаж шийдэх гэж байгаа юм гэдгийг та яг ямар бодлоготой байгааг хэлээд өгөөч.

Микрофон 3.

Ю.Отгонбилэг: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны яам Отгонбилиг. Тэгэхээр хүн ам зүйн асуудал болон гэр бүлийн хөгжлийн асуудлыг нэгтгээд нэлээд судалгаа, шинжилгээ бас харьцуулсан судалгаанууд хийж байгаад одоо яг Гэр бүлийн хөгжлийн тухай хуулийг манай яамнаас боловсруулсан байгаа. Энэ хуулийг 1 сардаа багтаж Улсын Их Хуралд өргөн барихаар бэлдэж байна. Энэ хуульд яг гэр бүлийн чиглэлтэй хүүхдийн мөнгө болон бусад тэтгэвэр, тэтгэмжийг нэгтгэж оруулахаас гадна гэр бүлийн хөгжлийн дэмжсэн сургалт, судалгаа, хөгжлийг дэмжсэн бусад дэмжих үйл ажиллагаануудыг тусгасан ийм хууль боловсруулаад өргөн барихаар бэлтгэж байгаа юм.

Б.Найдалаа: Дахиад тодруулаад асууя. Энэ юу асуугаад байгаа шүү дээ. Сайнзориг гишүүний тодорхой асуулт нь олон гишүүд бас энийг асуух гэж байгаа байх. Хөдөө орон нутагт охид, бүсгүйчүүд нь байхгүй хот руу явчхаад дандаа эрэгтэй, залуучууд үлдчихээд ийм тэнцвэргүй байдал үүсээд энэ бол гэр бүлийн асуудал биш, жендэрийн ч асуудал биш яг нийгмийн том асуудал байгаа байхгүй юу. Ийм том асуудал дээр өргөн барих гэж байгаа гэдэг хууль биш яг ямар бодлого хэрэгжүүлэх гэж байгаа юм бэ? Яаж шийдэх юм? Яг тэр асуудлыг шүү. Ерөнхий хүн ам зүй зүй гэж яриагүй шүү. Яг орон нутгийн тэр саяын асуудлыг. Микрофон 3.

Ю.Отгонбилэг: Тэгэхээр энэ яах вэ нэлээд өргөн асуудал боловсролтой ч бас холбогдож байгаа. Тэгэхээр 1 дүгээрт хүүхдийг 6 наснаас сургуульд оруулж байгаа нь эмэгтэйчүүд хүүхдээ харж сумын төвд очоод, эрчүүд нь ганцаараа хөдөө мал маллаж байгаа энэ асуудал бол яг энэ боловсролын яг Монгол энэ хөдөө аж ахуй, нүүдлийн мал аж ахуйтай энэ улсад яг хүүхдийн сургуулийн насыг эргэж харах шаардлагатай байгаа. Тэгэхээр энийг бас Засгийн газар дотроо бас холбогдох яамнууд дээр хамтарч ажиллах шаардлага үүсээд байна.

Нөгөө талаасаа энэ сурах энэ асуудал дээр эрэгтэй хүүхдүүдийг ахлах, дунд ангиас нь мал дээрээ юу гэдэг юм сургуулиас завсардуулах энэ боловсрол нь бага гаргах ч гэдэг юм уу ийм асуудлууд байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр гэр бүлийн хөгжлийг дэмжих бас төвүүдийг ажиллуулж бас малчдад болон бусад хөдөө аж ахуйн газар тариалан эрхлэгчдэд сургалт, дэмжлэг үзүүлэх, бас соён гэгээрүүлэх ийм чиглэлийн ажлуудыг манай яамнаас эх

эхлээд энэ жил 4 аймаг дээр Гэр бүлийн хөгжлийг дэмжих төвийг ажиллуулж байна. Цаашдаа бүх аймагт ажиллуулахаар ингээд төлөвлөөд ажиллаж байна.

Б.Найдалаа: Ойлголоо. Баярлалаа. Хариулт авлаа. Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Хариулт бас тийм хангалттай биш болчих шиг боллоо. Тайлантай холбогдуулаад бас Байнгын хорооноос тодорхой чиглэл Засгийн газарт өгөх байх. Энэ тал дээр сая Сайнзориг гишүүн, Найдалаа гишүүний хөндөж байгаа асуудлыг бид онцгой анхаарах ёстой. Яах аргагүй ингээд хөдөөд гэр бүлгүй, эхнэргүй эрчүүд олон болчихсон. Энэ онцгой анхаарах асуудал дээр бид бодлогогүй байгаад байна. Тэгээд бодлоготой болооч гэсэн чиглэл өгмөөр байгаа юм

2 дугаарт нь дахиад энэ нөгөө цус ойртолтын асуудал. Хэтэрхий төвлөрдөг, алслагдсан бүс нутагт, алслагдсан хязгаар нутгийн хилийн сумдад үндсэндээ өнөөдөр хүмүүс ингээд амьдралын эрхээр нүүдэг, шилждэг. Энд бас онцгой анхаарах ёстой. Тэгэхээр хүн ам зүйн бодлого дээр манай Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамныхан энэ юмнууддаа жоохон онцгой анхаараад тайландаа ийм ажил хийсэн, ийм ажил үр дүн гарлаа гэдгээс тусгагдаагүй байгаа бол одоо тусгаад өгөөч гэдэг дээр нэгэнтээ асуудал шийдэх гэж байгаа юм чинь уул нь бид тайлангаа танилцуулах ёстой хийж чад.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Түрүүний асуудал дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд яг чиглэсэн бодлого байхгүй байх юм байна. Ойлголоо. Энхнасан гишүүн асуулт асууна.

Л.Энхнасан: Та бүхний өдрийн мэндийг айлтгая. Ер нь жендэрийн эрх тэгш байдал манай гишүүд бүгдээрээ л ярьж байх шиг байна. Зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш, тэгээд эрэгтэйчүүдийн боловсрол, эрүүл мэндийн асуудал орхигдож байгаа учраас энэ нийгмийн тэнцвэргүй байдал маш их үүсэж байгаа. Түрүүн бас та хэд бүгдээрээ л ярьж байна.

Тэгэхдээ яамд хоорондын энэ бодлого ер нь уялдаа холбоо муу байх шиг байна. Боловсролын яамнаас ер нь асууя энэ эрэгтэйчүүдийн боловсролын хоцрогдол, ялангуяа хөдөө орон нутагт байгаа малчдын хүүхдүүд, ер нь малчдын сургууль гээд бий болж байгаа. Ер нь 6 наснаас нь хөдөө ч байсан, хотод ч байсан эрэгтэй хүүхэд, эмэгтэй хүүхдийн сурах тэр зан үйлдэл чинь өөр шүү дээ. Яг эд гоё сайхан тогломоор байгаа тэр үед нь эрэгтэй хүүхдүүдэд ингээд 8 цаг хичээл дээрээ суухад бас хэцүү байгаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр ер нь хөтөлбөр дээр яаж анхаар байна?

2 дугаарт, энэ боловсролын хоцрогдол энэ жишээлбэл их, дээд сургууль дээр эрэгтэйчүүдэд бараг квот тавих юм уу? Ингэж оруулах тийм ер нь юмыг судалж байна уу?

3 дугаарт, эрүүл мэндийн хоцрогдол эрэгтэйчүүд ингээд хэнэггүйдээ ч болоод байна уу? Ингээд ерөөсөө үзлэгт орчхоод цаашаа эмчлүүлдэггүй эс үгүй бол бүүр ордоггүй. Энэ дээр Эрүүл мэндийн яам бол ямар бодлого цаашдаа хэрэгжүүлэх гэж байна? Зүгээр 80-аас дээш гэсэн тийм хөтөлбөрүүд аймгуудад зарлагдаад байна лээ. Тэглээ гээд насжилт жилд хэдээр нэмэгдэх юм? Энэ 10

жилийн хоцрогдлыг хэдэн жилд нөхөх юм? Ийм бодлого байна уу Эрүүл мэндийн яамнаас асуумаар байна.

Б.Найдалаа: Боловсролын яам. Суугаарай микрофон 3 дээр, микрофон 3. Дараа нь Эрүүл мэндийн яам.

Б.Алтансүх: Гишүүний асуултад хариулъя. 2023 онд Улсын Их Хурлаас Боловсролын багц хуулиудыг баталсан байгаа. Боловсролын багц хуулиуд дээр жендэрийн эрх тэгш, ялгаатай байдлын талаар сургалтын байгууллага сургалтын агуулгад бид нар бүх чиглэлээрээ туссан. Сүүлийн 10 жилд бид нар сургалтынхаа хөтөлбөрийн агуулгуудыг бүгдийг нь боловсролын багц батлагдсантай холбоотой, шинэчилж байгаатай холбоотой 2025 онд бид нар СӨБ-ын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг бид нар үндэсний зөвлөлөөрөө батлуулаад хэрэгжүүлж байна.

Энэ дээр та асууж байсан жендэрийн тэгш байдлыг бид нар сургалтын суралцагч хүүхдүүдэд, бага насны СӨБ-ын хүүхдүүдэд хөвгүүд, охидыг ижил үүрэгтэй оролцуулах, энгийн үг зохиолоор танилцуулах, хүүхэд бүр өөрийн хүйсээс үл хамаарах тоглоом, номоо сонгох, өөрийн сонирхолтой гэх мэт сургалтын үйл ажиллагаа суралцахуйн чиглэлд арга зүйг бид нар тодорхой хэмжээндээ тусгаад ажиллаж байгаа.

Харин түрүүний тэр хөдөө орон нутгийн хүүхдүүдийг арай насыг нь өөр гэдэг Боловсролын хуульдаа бид нар 6 настай хүүхдийг ерөнхий боловсролыг эзэмшүүлэхтэй холбоотой тэр бол хуульд заасан байгаа. Үүгээрээ явж байгаа. Хоцрогдол байгаа. Түрүүн бас бид нар хэлж байсан. 2023-аас 24 онд завсардсан, хоцрогдсон 5095 залуучууд байсан, иргэд байсан. 2024-өөс 25 онд 4422. Түрүүн хэлсэн 2025-аас 26 онд бид нар 4000 суралцагчийг бид нар Насан туршийнхаа төвөөр дамжуулаад суралцаж байгаа. Асуулт боллоо.

Б.Найдалаа: Тэр оюутнуудын хүйсийн тэгш байдлыг хангахын тулд квот хийх тухай бодол, бодлого байгаа юу гэж асуусан даа. Минут байгаа болохоор би цаг хэмнээд шууд тодруулчихъя. Микрофон 3.

Б.Алтансүх: Ер нь их, дээд сургуульд суралцагчдын дийлэнх хувь нь эмэгтэй оюутнууд байгаа. Харьцангуй тэр их, дээд сургуулиас харин бодлого ерөнхийдөө бид нар хөтөлбөрийнхөө хүрээнд бодлогыг.../минут дуусав./

Б.Найдалаа: Байхгүй бол байхгүй л гэчихгүй юу даа. Энхнасан гишүүн тодруулж асуух уу? Эрүүл мэндийн яамнаас хариулчхаад болох уу? Микрофон 3.

Б.Туяа: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Туяа байна. Тэгэхээр эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хоцрогдол гээд яг Энхнасан гишүүний хэлсэн яг үнэн байгаа. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү бол 9.2 жил байгаад байгаа. Эндээс жилдээ 18 мянган хүн нас барж байна гэдэг энэний 66 хувь нь эрэгтэйчүүд байгаад байгаа юм. Тэгээд эрэгтэйчүүдийн нас баралт бол эмэгтэйчүүдтэй харьцуулах юм бол жилээс жилд нэмэгдээд энийг нь тэгвэл амбулаторийн үзлэгтэй нь харьцуулаад үзэх юм бол эрэгтэйчүүдийн амбулаторид үзүүлэх байдал эмэгтэйчүүдээс илүү хоцронгүй байгаад байгаа.

Ялангуяа яг харьцуулалт тоон үзүүлэлтээр харьцуулж үзэх юм бол эрэгтэйчүүд маань эмэгтэйчүүдийг бодох юм 1.6 дахин бага амбулаторийн үзлэгт хамрагдсан хамрагдсан гэсэн ийм судалгаа байгаад байгаа.

Тэгэхээр бид нар цаашдаа цаашдаа энэ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлж байгаа. Ялангуяа энэ 2021-2025 онд бид нар “Эрүүл чийрэг эр хүн” гэдэг энэ арга хэмжээг зохион байгуулаад энд.../минут дуусав./

Б.Найдалаа: Энхнасан гишүүн тодруулж асуух уу? Тодруулж асуучхаад нэмээд хариултаа авах уу? Энхнасан гишүүн тодруулж асууна.

Л.Энхнасан: Би үзлэг энэ тэрийг ойлгож байна. Тэгэхдээ үзлэгээс гадна гол нь эрчүүдээ төрүүлээд хамгийн нас барж байгаа чинь зүрх судас байгаа шүү дээ, хавдар, дараа нь гэнэтийн нас баралт байгаа шүү дээ. Тэгэхлээр энийгээ урьдчилж сэргийлэх, нийгмийн эрүүл мэнд тэгээд “mental health” гээд байгаа шүү дээ. Тэн дээр яаж анхаарч байгаа юм бэ? Одоо энэ тамхи, архи, төрөл бүлгийн энэ донтолт байгаа шүү дээ. Эндээс сэргийлэх. Жишээлбэл, би тамхины ажлын хэсэгт орж байгаа. Тамхинаас орж байгаа энэ татварын нийгмийн эрүүл мэнд ингээд энэ эрчүүдийнхээ эрүүл мэндэд зарцуулах хэрэгтэй байхгүй юу. Энэ дээр яам тодорхой юм бодож байна уу, санал өгсөн үү? Ер нь Нийгмийн эрүүл мэндийн хуулийн хэрэгжилт аягүй дутмаг байна. Энэ дээр цаашдаа анхаарах шаардлагатай байна. Зөвхөн урьдчилан сэргийлэхэд орлоо гээд тэгээд яахгүй шүү дээ. Ер нь ирэх.../минут дуусав./

Б.Найдалаа: Микрофон 3 гүйцээж хариулъя.

Б.Туяа: Тэгэхээр бид нар яг цогц арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг яг эрчүүдийн эрүүл мэндэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж байгаа. Дөнгөж сая гэхэд эрэгтэйчүүдийн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөөг батлаад хэрэгжүүлж байна. Мөн 2022-2026 онд хэрэгжүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн арга хэмжээний бас төлөвлөгөө байгаад байгаа. Энэ дээр яг мансууруулах бодис, эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр яг тодорхой арга хэмжээнүүдээ авч хэрэгжүүлж байгаа.

Дээрээс нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль маань 2024 оны 4 сараас эхлээд хэрэгжээд явж байгаа. Энэ дээр бас яг цогц арга хэмжээнүүдийг бас авч хэрэгжүүлэхээр ингээд тусгаад ажиллаж байгаа.

Б.Найдалаа: Энхнасан гишүүн тодруулах минут байгаа. Энхнасан гишүүн тодруулж асууя.

Л.Энхнасан: Тэр түрүүн асуусангүй хариулсангүй 10 жил хоцрогдож байгаа шүү дээ. Энийг хэдэн жилд нөхөх боломжтой юм? Ямар нэгэн тийм судалсан юм байна уу? 1 жилд эрчүүдийн эрүүл мэндэд анхаарлаа гээд олон улсын жишгээр тэгвэл хэдэн нас нэмэгдэх юм? Энэ хэзээ ингээд нөхөгдөх юм? Эмэгтэйчүүд нь бас л эрүүл мэндээ анхаараад л бүүр урт наслаад байна шүү дээ. Тэр дээр ямар нэгэн судалсан гэсэн ,бодсон тийм юм байна уу? Зүгээр урт насалъя гээд л.../минут дуусав./

Б.Найдалаа: Микрофон 2 уу? Микрофон 2.

А.Адилбиш: Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Адилбиш байна. Энхнасан гишүүний асуултад тодорхой хариултыг өгье.

Тэгэхээр 2018 онд бид яг анх Монгол Улс ер нь энэ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 10 насны зөрүүтэй байна гэдэг энэ асуудлыг ярьж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, 2018 онд эмэгтэй хүн 75.7 насалж байсан байна. Эрэгтэй хүн болохоор 66.1. Өөрөөр хэлбэл, 9.6 жилийн зөрүүтэй байсан. Өнөөдөр 2025 он энэ зөрүү 9.2 болсон байгаа. Ер нь 27 он хүртэлх яг энэ эрэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024-өөс 27 гээд энэ 3 жилийн хугацаатай бодлого нь баримт бичгийг бид гаргачихсан ингээд явж байгаа. Тэгээд 27 онд 9 жил болгож буулгана гэдэг энэ зорилтыг дэвшүүлчихсэн байгаа. Тийм.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Миний асуулт Боловсролын яам болон Эрүүл мэндийн яамнаас асууя. Боловсролын яамнаас тодруулах гээд байгаа зүйл нь хөвгүүд маань яг хэдэн настайдаа өөрийнхөө хариуцлагаа ойлгодог болоод ямар хичээлээр, хэнээр заалгаж өөрийнхөө эрүүл мэндэд анхаардаг болдог энэ чиглэлийн сургалтуудыг ер нь авдаг юм бэ? Ялангуяа яг аль насан дээр эрэгтэй хүүхдэд өөрийнхөө гэр орноо өөрөө хариуцах, хоол ундаа хийх, хувцас хунараа угаах гээд бид нарын гэр бүлийн зөрчлийн асуудал болсон зан үйлүүдийг ямар хичээлээр ямар албан боловсролоор ер нь хөвгүүд авдаг ийм тогтолцоотой юм манайх? 1 дүгээрт. Охид ч гэсэн ялгаагүй. Тэрийг асууя. Аль хичээлээр, хэнээр заалгаад өнөөдөр хөвгүүд маань, охид маань ялгаагүй адилхан бие хүний хариуцлагаа олж авдаг юм бэ? Ийм бодлогыг бас тодруулмаар байна

2 дугаарт, Эрүүл мэндийн яамнаас би асууя л даа. Монголд амиа хорлож байгаа хүмүүсийн 80-85 хувь нь эрэгтэй байгаа. Тэгээд тэдний 15-аас ихэнх нь дунджаар 15-44 насных гээд судалгаа байгаа шүү дээ. Залуучууд маань яагаад амиа хорлодог юм оо шалтгаан нь? Тэгээд дараа нь би тодруулъя гэж бодож байна.

3 дугаарт, ер нь манай улс угаасаа энэ эрчүүдэд тулгадаг хорт зуршил буюу “toxic masculine” үзүүлэлт өндөртэй орон. Энэ чиглэлийн судалгаан дээр тулгуурласан ямар бодлого гаргасан юм бэ? Энэ талаар бас Засгийн газар байдаг юм уу, холбогдох хүмүүс нь хариулна уу. 3 асуултаа сонсоод тэгээд тодруулъя.

Б.Найдалаа: Микрофон 3.

Б.Алтансүх: Боловсролын яам Алтансүх. Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга. Ерөнхий боловсролын бага сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулаад явж байна. Үүн дээр жендэрийн эрх тэгш байдлыг агуулгыг тусгаад явж байна. 1 дүгээр ангид хүүхдүүдэд хувь хүний ялгаатай байдлын мэдлэг хүлээн зөвшөөрдөг, бусдыг гомдоохгүй байхад анхаардаг гэсэн агуулгыг ер нь тусгаж ажиллаж байгаа.

2 дугаар ангид хүмүүс нэг нэгэндээ татагдаж шохоорхох энэ маань эрүүл мэндийн хичээлээр байгаа. Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт ижил хүйсийн хүмүүс татагдах тохиолдол байдаг гэдгийг тайлбарлаж чаддаг агуулгыг тусгаад явж байгаа. Эрүүл мэнд хичээлийн 4 дүгээр ангид хүйсийн болон бэлгийн чиг

баримжаатай ялгаатай байдлыг ойлгож, хүндэтгэлтэй ханддаг болно гэж ер нь тодорхойлолтыг тусгаж байгаа. 5 дугаар ангид бэлгийн амьдралтай олон янзын мэдрэмж, сэтгэл хөдлөл гэдгийг мэдэх, ижил болон эсрэг хүйсийн хүн бие махбод, сэтгэл санаан татагдах хэв шинжийг ойлгох гэх мэтээр анги анги өгсөх тутмаа эрүүл мэндийн хичээлд нэлээн нарийвчилж орж байгаа.

Тэгэхдээ энийгээ шууд энэ утгаараа биш арай хүүхдэд ойлголцохуйц байдлаар багш нарт нь заахаар сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж байгаа.

Б.Найдалаа: Дараагийн хариулт нь. Микрофон 3 дээр сууя.

Б.Туяа: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Туяа. Тэгэхээр 15-44 насны эрэгтэйчүүдийн дунд амиа хорлох үзэгдэл өндөр байгаа гэдэгтэй санал нэгтэй байна. Мэдээж энэ дээр эрэгтэй хүүхдүүд, эрэгтэйчүүдийн маань энэ архи, тамхи, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол зэрэг энэ буруу зуршил түгээмэл байдагтай 1 дүгээрт холбоотой гэж үзэж байгаа

2 дугаарт, энэ эрэгтэйчүүдэд чиглэсэн нарийн мэргэжлийн, төрөлжсөн мэргэжлийн, сэтгэцийн эмч, мэргэжилтэн, эрэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх энэ кабинетуудын тоо хэмжээ дутагдалтай байна гэж харж байгаа. Одоогоор бид нарт Монгол Улсын хэмжээнд 28 урлаг, андрологийн кабинет үйл ажиллагаа явуулж байгаа. Энэнээс гадна Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг үндэсний төвүүдэд өсвөр үеийнхэнд зориулсан кабинетуудыг бас ажиллуулж байгаа.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулж асууна.

О.Саранчулуун: Судалгаанууд байдаг л даа гэр бүл салалтын. Гэр бүлийн зөрчлийн нэлээн их асуудал нь зан үйлийн асуудлууд байгаа. Хөвгүүд маань гэрээ цэвэрлэж, хоол хийж, гэр бүлийн хариуцлага үүрэгтэй холбоотой асуудал дээр сул байна.

Тийм учраас энэ хоёрын хооронд хүйсийн зөрчил үүсэж байна. Энийг бид нар үзэл бодлын гэдэг нэрээр өнөөдөр судалгаан дээр гаргаж ирж байна. Тэгэхээр энэ тухай хаана заадаг юм бэ л гээд байгаа байхгүй юу. 1 дүгээрт нь тэр Боловсролын яамны асуулт нь.

Бид нар ялгаатай байдлын тухай ойлгож болж байна. Тэгвэл яагаад өнөөдрийг хүртэл хөвгүүд уйлж болохгүй, эрчүүд ийм байх ёстой гэдэг хандлага байсаар байгаа юм бэ? Яагаад өнөөдрийг хүртэл гэр бүл салалт өнөөдөр зан үйлийн асуудлаас болоод шийдэгдэхгүй байгаа юм? Энэ дээр Эрүүл мэндийн яаман дээр ямар шийдэл байгаа юм бэ? Тэгээд ийм архи, тамхи, хорт хэрэглээ гээд байгаа юм. Тэр чинь дахиад л сэтгэл зүйн асуудал байгаа байхгүй юу

Тэгэхээр сургууль дээр энэ асуудлыг хэн, ямар бүтцээр шийдэж байгаа вэ гэдгийг Боловсролын яамнаас дахиад асуумаар байгаа байхгүй юу. Хэн энийг хариуцах юм Монгол Улсад? Хөвгүүдийнхээ нийгмийн хариуцлагыг, өөрийнхөө, хувь хүний хариуцлагыг сайжруулахын тулд боловсролын ямар.../минут дуусав./

Б.Найдалаа: Алтансүх дарга хариулъя. Хэдэн хичээлээр саяын агуулгуудыг хүргэж байгаа юм бэ? Базаад, дүгнээд тодруулж хариулъя. Микрофон 3.

Б.Алтансүх: Нэмж хариулъя. Эрүүл мэндийн хичээл ордог. Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр бас явж байна. Нийгмийн ухааны хичээлээр хүүхдүүдийг сургадаг. Тэгээд Хүн ба орчин, Хүн ба нийгэм, Хүн ба байгаль гэх мэт хичээлүүдээр бид нар боловсролын сургалтын агуулгадаа тусгаад 1-5 дугаар ангид явдаг.

Аюулгүй амьдрах ухааны хичээл 1-12 дугаар ангид, эрүүл мэндийн хичээл 1-12 дугаар ангид. Энийг нь гол хичээлүүдээрээ дамжуулж хүүхдүүдэд тухайн асуудлыг сургахаар туссан байгаа. Тийм.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулах 1 минут байгаа. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Би хичээлийн нэрийг ойлгоод байна л даа. Тэгээд хэн заадаг юм бэ? Сургууль дээр нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гээд бид нар уул нь яриад байгаа шүү дээ. Тэр хүмүүс өнөөдөр эрэгтэй хүүхдүүдийг энэ амиа хорлоод байгаа шалтгаанд чинь сэтгэл зүйн асуудлууд яригдаад байна шүү дээ. Зан үйлийн асуудлууд яригдаад байна. Энийг өнөөдөр хэн хариуцаж байгаа юм бэ л гээд байгаа байхгүй юу. Ямар бодлого байгаа юм Боловсролын яаман дээр?

Б.Найдалаа: Микрофон 3

Б.Алтансүх: Тухайн хичээл заадаг Эрүүл мэнд, Нийгмийн ухааны хичээл заадаг багш нараас гадна ангийн багш гол үүрэгтэйгээр орж явдаг. Мөн сургуулийн тэр нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар бас тодорхой хэмжээнд бид нар сургалтынхаа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдүүдэд дээрх агуулгатай бид нар агуулгатай асуудлыг хичээлдээ бид нар оруулаад ажиллаж байгаа. Тэгээд сургуулийн өөр өөрсдийн онцлогууд байгаа. Тухайн сургуулийн захирал, удирдлага, энэ нийгмийн ажилтан эд нарын идэвх санаачилгаас шалтгаалж, хүүхдүүдэд бас харилцан адилгүй бас хүүхдэд мэдлэгийг олгосон байдаг юм.

Б.Найдалаа: Энэ юу юм байна тээ янз янзын багш нар, янз янзын ингээд сэглэж тал талаас нь заадаг юм байна зөв үү? Эрүүл мэндийн хичээл гэж ороод хажуугаар нь. Микрофон. 3

Б.Алтансүх: Чиглэлээрээ заана гэсэн үг. Анги хариуцсан багш бол тухайн ангийнхаа хүүхдүүдийг сурч боловсрохоос гадна өөрийнх нь хариулт алга.

Б.Найдалаа: Жоохон тодорхойгүй л хариулт байна яг үнэнийг хэлэхэд. Ингэвэл яадаг юм тэр манай энэ 2 Байнгын хорооны, ялангуяа Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хамаарах хүрээнд нийгмийн хамаг асуудал байгаа байхгүй юу. Асуудал болгон дээр эцсийн дүндээ тэр чинь нэг л багш байгаа нэг л сургууль байгаа нэг л хүүхэд байгаа. Тэр хичээлүүдээ нэгтгээд зөв хүн байх тухай л хичээл байгаад байгаа байхгүй юу. Энийг нэгтгээд арай ингээд бүүр багаас нь том болтол нь ингээд программыг нь, хөтөлбөрийг нь хөгжүүлээд ингээд явж болдоггүй юм уу? Эрүүл мэндийн хичээл гэж юм зааж байгаад л өөр жендэрийн хичээл гэж заалттай биш дээ. Яг энэ нэгтгээд ингээд явж болдоггүй юм уу? Ийм бодлого байхгүй юм уу? Хөтөлбөр шинэчилж байгаа гэсэн иймэрхүү юм байгаа юм уу? Эсвэл Эрүүл мэндийнхээ хичээлийг хэдэн цаг болох бэ тухай шийдэх гээд байгаа юм уу? Микрофон 3.

Б.Алтансүх: Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар анги даасан багштай ер нь хамтран хэрэгжүүлж ажилладаг энэ дээр.

Б.Найдалаа: Тэгвэл энэ ерөнхийдөө додомдож байгаа л юм байна. Ойлголоо. Баярлалаа. Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Засгийн газар 20-24, 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, тэр дундаа эрт илрүүлгийг зохион байгуулах, түүнд бас тодорхой шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг баталж яваа. Энэ эрт илрүүлэгт ер нь өнөөдрийн байдлаар хэчнээн хүн хамрагдсан байна? Хүйсээр нь харьцуулбал эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн харьцаа энэ эрт илрүүлэгт хэрхэн яаж оролцсон, хамрагдсан байдаг юм?

Нөгөө талаар ингээд зүгээр эрт илрүүлэгт хамруулаад орхичих биш эрт илрүүлгээр гарч ирсэн тэр шинжилгээгээ бариад дараагийн шатын эмчилгээ, нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээнд хамрагдах энэ байдлаараа эрчүүд, эмэгтэйчүүдийн тэр өөрсдийнхөө эрүүл мэндэд анхаарч байгаа байдал нь ямаршуухан байдаг юм. Энэ дээр манай Эрүүл мэндийн яам гэдэг юм уу холбогдох газрууд хийсэн судалгаа юмнууд байдаг юм уу үгүй юү? Яагаад ингэж асууж байна гэхээр бас л нөгөө эрчүүд маань хайнга, хэнэггүй байдлаас болоод л эрт илрүүлэгт шахуулж байж байгаад л ордог. Ингээд ер нь хавдрыг эмчилж болно шүү дээ. Эхний шатад нь. Тэгээд хайнга байдлаасаа болоод хүндрүүлээд 2, 3 дугаар үе шатад нь оруулчихсан хойноо л гэв гэнэтхэн эмчлэх гээд үзээд ингээд оройтсон бороо болоод байгаа шүү дээ.

Тийм учраас энэ тал дээр шинжилгээ, тооцоо, судалгаа хийсэн юм байж, энэ дээр цаашдаа Эрүүл мэндийн яам, холбогдох ямар арга хэмжээг авдаг юм бэ? Тэр дундаа эрчүүдийг үргэлжилсэн эмчилгээнд хамруулах, тухайн байгууллагын удирдлагуудад энэ чиглэлээр нь та манай байгууллагын тэдэн албан хаагчдаас тэд нь ийм цаашдаа эмчлүүлэх шаардлагатай болчихсон юм байна. 1 дүгээр шатад нь байгаа юм байна. Ингээд үргэлжилсэн эмчилгээнд нь оруулах чиглэлийн энэ чиглэлээр ямар арга хэмжээг авдаг юм бэ гэдэг ийм асуулт нэгд байна.

Хоёрт, улс төрийн та бүхний энэ гаргаж өгсөн тайлангаас харахаар хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх гээд үгүй үгүй гээд байгаа юм л даа. Аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч, дүүргийн Засаг дарга, зүгээр дүүргийн Засаг даргын орлогч гээд ингээд бүх шатны. Хэрэгжилт нь болохоор хангалтгүй гээд бүгдээрээ ингэ дүгнэчихсэн. Энэ албан тушаалуудыг бас ялгаатай авч үзэх ёстой хэрэгтэй байгаа юм. Улс төрийн томилогддог албан тушаал, сонгогддог албан тушаал хоёр чинь ялгаатай байхгүй юу. Яг энэ жендэрийн асуудлыг ярих албан тушаал бол томилогддог албан тушаал дээр томилж байгаа эрх бүхий субъектүүд яг энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд томилгоо хийх ёстой байхгүй юу.

Жишээлбэл, Монгол Улсын Ерөнхий сайд одоо бол шинэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Засгийн газар кабинтаа өөрөө томилдог болчихсон, Их Хурлаар сонгогддог болчихсон. Яг өөрөө мэдээд томилж байгаа хүрээнд яг энэ хуулийн хүрээнд энэ томилгоогоо хийх ёстой. Тэгэхээр өнөөдөр яаж байна уу сайд нар 2-3-хан нь эмэгтэй сайд байна гэдэг чинь хуулиа хэрэгжүүлэхгүй байна гэсэн л үг шүү дээ. Доошоод яг.../минут дуусав./

Б.Найдалаа: Минут нэмж өгье.

Ц.Сандаг-Очир: Доошлоод мөн адилхан. Сайд очоод яаман дээрээ өөрийнхөө томилдог газар, хэлтсийн дарга нараа яг ийм байдлаар томилох ёстой. Энэ дээр хуулийн хэрэгжилтийг дүгнэх ёстой юм байгаа юм.

Сонгогддог албан тушаал дээр энэ хуулийн хэрэгжилтийг дүгнэхэд их хэцүү. Тэртээ тэргүй эмэгтэйчүүд бүх шатны, улс төрийн намууд бол хуулиа мөрдөөд бүх шатны сонгуульд нэр дэвшигчийн 30 хувь, цаашлаад 40 хувь нь эмэгтэйчүүд байна гээд нэр дэвшүүлэлтээ хуулиа бариад хийчхэж байна. Ард түмний дундаас сонгогдох гэж байгаа учраас хэнийг нь яаж сонгох юм гэдгийн бид бол мэдэхгүй.

Тийм учраас энэ хуулийн хэрэгжилтийг ингэж юу гэж хэлэх гээд байна гэхээр ялгаатай авч үзэх ёстой. Яг томилогддог албан тушаалууд дээр жендэрийн албан байдлуудаа эрх бүхий албан тушаалтнууд барьж чадаж байна уу үгүй юу гэдэг тал дээр та бүхэн цаашдаа үнэлгээ, дүгнэлтээ гаргаж цаашлаад Засгийн газар, сайд нарт газар, хэлтсийн дарга нарт энэ чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт энэ чиглэлээр хуулиа барь гэдэг ийм чиглэлээр чиглэл өгч ажиллах ёстой. Энэ дээр та бүхэн.../минут дуусав./

Б.Найдалаа: Хариулт Бямбацогт сайдаас эхэлнэ.

С.Бямбацогт: Сандаг-Очир гишүүнтэй санал нэг байна. Сонгогддог албан тушаал дээр бол ард түмний итгэлийг даагаад сонгох, сонгогдохгүй тэн дээр бол жендэрийн харьцаа бол тэрүүгээр явчихаар тэнд бид заавал хууль гэх юм байхгүй. Хуульд заасан квотын хүрээнд дэвшүүлнэ. Үнэхээр ард түмний итгэл даагаад хариуцлага хүлээгээд, сонгогдоод, сонгогдсоныхоо дараа хүлээн зөвшөөрөгдөөд цаашаа карьер нь улам өсөөд, нэмэгдээд сайд, Засгийн газрын гишүүн гээд дахин сонгогдох гээд энэ боломж нь бол нээлттэй байгаа. Энэ боломж дээрээ байж чадах, чадахгүй асуудал бол тэр тухай хувь хүнтэй холбоотой асуудал. Томилогдох албан тушаал дээр ч ялгаа байхгүй. Томилдог, томилогдчихоод итгэл даадаггүй, манлайлал гаргаж чаддаггүй, үлгэр дуурайлал үзүүлж чаддаггүй үүнээсээ болоод дараа дараагийнхаа боломжийг хаадаг ингээд дэвшүүлэхээр чинь, томилохоор чинь болдоггүй юм байна лээ шүү дээ. Ингээд байдаг юм байна лээ шүү дээ. Ийм болохоор дэвшүүлж болдоггүй, нэр дэвшүүлж болдоггүй, ийм болохоор томилж болдоггүй, ингээд болохгүй байна шүү гээд асуудлууд гардаг л даа.

Тийм болохоор хаана хаанаа бид анхаарах ёстой. Тэр сонгогддог, томилогддог албан тушаал дээр хашиж байгаа улсууд маань илүү хариуцлагатай, илүү нэр хүндтэй, илүү ёс зүйтэй, илүү манлайлал үзүүлж, хүлээн зөвшөөрөөгдөж ажиллаж чадах юм бол цаашдаа өшөө илүү сонгогдох, томилогдох боломжууд нэмэгдэнэ. Энэ талдаа хаа хаанаа бас анхаарах ёстой юм байна лээ. Тэгэхгүй зөвхөн эрхээ эдэлнэ гээд дайраад байдаг, нөгөө талд нь эрхийн цаад тал талд бас үүрэг гээд юм байж байгаа. Үүргээ биелүүлэх тал дээр бид нар тодорхой ямархуу байдлаар чиглүүлэх юм, энэ тал дээр тодорхой зохицуулалтуудыг бодох ёстой. Эрх, үүрэг хоёрын нэгдэл хангагдах ёстой гэдэг дээр анхаарах ёстой. Санал нэг байна.

Б.Найдалаа: Эрүүл мэндийн яамнаас бас асуулт байсан. Микрофон 3.

Б.Туяа: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Бодлого8 төлөвлөлтийн яам Туяа байна.Тэгэхээр 2022 оны 5 сарын 1-ээс улсын хэмжээнд хүн амын дунд халдварт болон халдварт бус өмчөөс урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулсан. 2025 оны 10 сар хүртэл үргэлжлээд энэ хугацаанд нийтдээ нийт хүн амын 50 орчим хувь буюу 1.7 сая иргэн маань энэ эрт илрүүлэгт хамрагдсан байгаад байгаа. Эндээс ингээд аваад үзэхээр хүйсийн байдлыг нь харах юм бол 46.6 хувь л эрэгтэйчүүд эзэлж байгаа. Эмэгтэйчүүдийн хувьд 56.4 хувийг эзэлж байгаа.

Тэгэхээр эндээс харахад эрэгтэйчүүдийн дунд маань бас л бидний халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалт бол бас өндөр байгаад байгаа. Бид нар халдварт бус өвчний тархалтыг үндэсний хэмжээнд таван жил тутам ер нь судалгаагаа үндэсний хэмжээнд явуулдаг. 2019 оны байдлаар эрэгтэйчүүдийн дунд тамхи таталт 50 хувь нь.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Микрофон 3.

Б.Туяа: Мөн 50 хувь нь архи уудаг гэсэн ийм үзүүлэлттэй байсан бол энэ эрт илрүүлгээр гарсан шинжилгээгээр мөн эрэгтэйчүүдийн дунд архи, тамхины хэрэглээ буюу яг энэ халдварт бус өвчин үүсгээд байгаа эрсдэлт хүчин зүйлсийн тархалт маань өндөр байна гэсэн ийм үзүүлэлт гарч ирж байна.

Тэгэхээр цаашдаа бид бүхэн яг энэ эрт илрүүлгийг нийт хүн амыг хамарсан биш одоо энэ эрт илрүүлгээс гарсан судалгаан дээр үндэслээд, үр дүн дээрээ үндэслээд зорилтод бүлэгт чиглэсэн ялангуяа энэ ажил олгогч нарын ажилтнуудыг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгтээ хамруулах, мөн насны бүлэгт чиглэсэн эрсдэлт хүчин зүйлээр нь зорилтод бүлэгт чиглэсэн илүү эдийн засгийн үр ашигтай урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг хэрэгжүүлэхээр бодлого, чиглэлээ болгоод явж байгаа. Гол нь эрэгтэйчүүдийн хувьд маань эрүүл мэндийг эрэлхийлэх буюу эмнэлэгт үзүүлэх байдал маань эмэгтэйчүүдтэй харьцуулах юм бол харьцангуй доогуур байгаад байгаа. Түрүүний би бас хэлсэн байгаа. Амбулаторийн үзлэгийн тоог харах юм бол эрэгтэйчүүд маань эмэгтэйчүүдтэй.../минут дуусав./

Б.Найдалаа: Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

Ц.Сандаг-Очир: Бага цагтай оновчтой хариулбал сайн байна. Энэ Засгийн газар бүх шатанд оны эцэст ажил дүгнэдэг. Ер нь энэ Засгийн газар ажил дүгнэхдээ энэ жендэрийн асуудлыг харгалзаж үзэх шалгуур шаардлага байна уу? Энэ компаниуд, энэ байгууллагын удирдлагууд, аймаг, нийслэл, сум, дүүрэг, яам, агентлаг, төрийн байгууллагууд ажил дүгнэхдээ энэ жендэрийн асуудлыг ер нь хэрхэн, яаж авч үзсэн юм гэдэг чиглэлээр шалгуур үзүүлэлтийг оруулж өгсөн асуудал байна уу хөшүүрэг? Нэгт.

Хоёрт, энэ эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр ер нь Монгол Улсад хэчнээн ТББ байдаг юм? Эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр хэчнээн ТББ байдаг юм? Энийгээ ер нь тооцож үзсэн, гаргаж үзсэн судалгаа юм байдаг юм уу? Энэ чиглэлийн дагуу бас бид нар чинь эрчүүддээ яаж ханддаг юм гэдэг ийм багцаа харагдана даа. Энийг та бүхэн хэлж өгөөч.

Б.Найдалаа: Хариулт. Сая ТББ Жендэрийн үндэсний хороо юу? Хэн хариулах уу? Микрофон 2.

А.Адилбиш: Баярлалаа. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ 2011 онд батлагдсан жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хууль яг энэ томилогдох болоод сонгогддог энэ албан тушаалууд дээр яагаад хангалтгүй, хэрэгжилт хийгдэхгүй байна гээд асууж байна. Таны асуулттай санал нэг байна.

Тэгэхээр өнөөдөр энэ хуулийн хэрэгжилтийн хариуцлага тооцох механизм бид нарт үндсэндээ байхгүй байгаад байна. Хэрэгжүүлээгүй бол яаж хариуцлага тооцох юм бэ гэдэг нь байхгүй учраас ингээд л яваад байгаа. Тиймээ квотын хэрэгжилтийг хянах байдлаар хорооноос жил бүр яг энэ хүйсийн тэнцвэртэй байдлын тайлангаа аваад Ерөнхий сайдын ахалдаг Жендэрийн үндэсний хорооны бүх гишүүддээ яг одоогийн, өнөөдрийн нөхцөл байдал нь ямар байгаа юм бэ гэдэг энэ мэдээллээ өгөөд ингээд явж байдаг. Тэгэхлээр үндсэндээ бол Жендэрийн үндэсний хороо бол яг энэ жендэрийн асуудлаарх салбар дундын уялдаа, бодлогыг хангах чиглэл дээр хорооны бүх гишүүдтэй болоод бүх яамнууд.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Микрофон 2.

А.Адилбиш: Бүх мэдээллүүдийг хөндөөд явж байгаа. Мөн та дахиад бас чухал асуудлуудыг хөндлөө. Яг энэ өнөөдөр Монгол Улсад хэрэгжиж байгаа энэ ханалт үнэлгээ, шинжилгээний энэ асуудал дээр дүн, тайлан тавьж байгаа энэ асуудал дээрээ бид нар энэ жендэрийн эрх тэгш байдлыг хангах ямар үнэлгээ, дүрэм, журмаа оруулаад явж байгаа юм бэ гэж асууж байна. Ер нь сүүлийн 1-2 жилийн хугацаанд бол энэ хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт дээр жендэрийн эрх тэгш байдлыг хангаж байна уу үгүй юу гэдэг зүйлээ бас оруулаад явж байна харьцангуй.

Гэхдээ энэ бол тогтмолжоогүй байна. Тогтмолжиход тодорхой хэмжээний хугацаа шаардлагатай байгаа. Ер нь яг Жендэрийн үндэсний хорооны яамнууд дээр байгаа жендэрийн асуудал хариуцсан салбар зөвлөлийн дарга 21 аймаг 9 дүүрэг дээр, нийслэл дээр байгаа Жендэрийн салбар хорооны дарга нартайгаа нэлээн тулж ажиллаж, асуудлыг яг бодитоор нь шийдвэрлэх энэ зайлшгүй шаардлага байгаа. Энэ чиглэлд ирэх 2026 онд илүү үр дүнтэй ахиц гаргасан мэдээтэй тантай уулзана.

Б.Найдалаа: Хариулт болсон уу? Түрүүн эхний асуудал байсан шүү дээ. Тэр жендэрийн юуг хангаагүй бол тэр талаар мэдээлэл байхгүй юу? Сая хариулаагүй юу. Микрофон 2.

Эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан ТББ хэд хэд байдаг юм бэ, харьцаа нь ямар байдаг юм бэ. Хариулаарай микрофон 2.

А.Адилбиш: Ер нь Жендэрийн үндэсний хороо бол энэ дэргэдээ жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, мөн жендэрийн эрдэмтэн судлаачдын бүлэг Жендэрийн үндэсний хорооны дэргэд ямарваа нэгэн цалин хөлс, урамшуулалгүйгээр ийм 2 бүлэг ажилладаг. Мэдээж хэрэг иргэний нийгэм байгууллага бол Жендэрийн үндэсний хороотой хамтарч ажилладаг маш том бүрэлдэхүүн хэсэг, тогтмол хамтарч ажилладаг эрэгтэйчүүдийн 20 орчим ТББ байна.

Мөн Ерөнхий сайд ахалдаг Жендэрийн үндэсний хороонд Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Монголын эрэгтэйчүүдийн холбоо гэсэн төлөөлөлтэй том

2 байгууллага маань хорооны гишүүнээр тасралтгүй ороод ингээд үйл ажиллагаанд оролцоод явж байгаа.

Б.Найдалаа: Эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ТББ-уудын тооны харьцаа ямар байдаг юм бол? Энэ талаар мэдээлэл байдаг юм уу эсвэл та хэд байдаггүй бол энэ цуглуулаад л явж баймаар. Микрофон 2.

А.Адилбиш: Эрэгтэйчүүдийн чиглэлд ажилладаг 20 орчим ТББ, эмэгтэйчүүдийн ТББ бол 30 орчим бол байна. Тооны хувьд 10-ын зөрүүтэй байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжаргал: Би энэ танхимд байгаа Улсын Их Хурлын гишүүддээ нэг мэдээлэл өгөх нь зөв байх. Хэдүүлээ жендэрийн бодлого ярихаар эрэгтэй, эмэгтэй гээд хоёр талцалд хуваагдах ийм чиг хандлага руугаа орох гээд байх юм. Энийгээ бүгдээрээ жоохон түрдээ ингээд байж байгаад жоохон том дүр зургаар нь хараасай гэж бодож байна. Тэгээд энд байгаа эрэгтэй сайд нартаа, дарга нартаа, Их Хурлын гишүүддээ хэлэхэд өнөөдрийн энэ ганц бие малчин, хөвгүүдийн боловсролын асуудал гээд ингээд эрчүүдийн маш олон хөгжлийн хоцрогдол үүсээд байна гэдэг асуудал өнгөрсөн 30 жил дийлэнх олонх нь эрчүүд засаг барьж байхдаа гаргасан бодлогын чинь үр нөлөө. Та нарын өөрсдийн чинь шүү дээ.

Энийг өнөөдөр орж ирээд гайхаад эмэгтэйчүүд улс төрд олноороо боллоо, одоо хөдгүүдээ ярья гээд ингээд ийм талцал руу аваачих ямар хэрэгтэй юм? Тэгэхээр яах гэж эмэгтэйчүүдийг бодлого гаргах энэ түвшинд аваачаач ээ гээд байгаа вэ гэвэл энэ бодлогыг чинь бүгдийг нь бүхлээр нь томоор нь харах гэж хамтдаа энэ шийдвэрийг гаргадаг байя, аль аль нөхцөл байдлыг хардаг байя гэж л бид нар тайлангийн асуудлыг хэлэлцэж байгаа. Тэгэхээр энийг бас жоохон утга учиртай бүгдээрээ хармаар байна. Тайланд бас утга учиртай хандмаар байна гэж хүсэх гээд байгаа юм.

1925 оны Монгол Ардын намын Хяналтын хорооны хурлын тэмдэглэл дээр би бүр 1925 оны хурлын тэмдэглэл ярьж байгаа шүү. Аль нэг аймгийн засаг ноёноор эмэгтэй хүн байж болох уу гэж 1925 онд ярьж байсан байдаг юм. 100-н жилийн дараа бид нар түүхийг дахиад ярьсан хэвээрээ л байна шүү дээ. Тэгэхээр орон нутаг дахь эмэгтэйчүүдийн асуудал, эрэгтэйчүүдийн асуудал чинь хэзээ ч сайжрахгүй. Энэ дээрээ ахиц, дэвшил гаргахгүй бол энэ бол ахиц гарахгүй гэсэн үг.

Хоёр дахь нэг багц асуудал нь хөвгүүдийн боловсролын асуудал нэлэн яригдаж байна. Монгол Улсад хөвгүүд боловсролоор хөндийрөхөд нөлөөлж байгаа хүчин зүйлийн судалгааг 2024 онд Боловсрол эвсэл байгууллага хийсэн байгаа юм. Хөвгүүд, хөдөөгийн хөвгүүд яагаад боловсролоос хөндийрөөд байна вэ гэдгийг том дүр зургаар нь, макро түвшинд нь, дунд түвшинд нь ингээд яг микро хүнээс өөрөөс нь шалтгаалаад ямар хүчин зүйлүүд байна вэ гэдгийг судалчихсан. Бодлогын шийдлүүдийг санал болгочихсон байгаа юм. Харамсалтай нь энэ манай яамныхан энэ хэдүүлээ судалгаанууд уншаад салбар дундын уялдаа гэдэг юмыг энэ танхимд аягүй сайн ярихгүй бол ерөөсөө болохгүй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нэг асуудлыг дангаараа шийдэж хэзээ ч чадахгүй. Боловсролын яам дангаараа шийдэж хэзээ ч чадахгүй.

Жишээ нь, хөвгүүд яагаад боловсролоос хөндийрдөг бэ, хувь хүнээс шалтгаалж байгаа хүчин зүйл нэгдүгээрт спортыг чухалчилдаг юм байна. Эцэг, эхийн оролцоо бага юм байна, үл хайхардаг юм байна хөдөөгийн хөвгүүд. Санал нэг биз дээ та нар тээ? Тэгвэл мисо түвшинд нь буюу яг дунд түвшинд нь, орчинд нь хурдан морь унадаг нь өөрөө хөвгүүдийн боловсролоос хоцордог нэг шалтгаан байна.

Хүүхдүүд хөдөлмөр эрхэлдгийн байна. Хоёр дахь шалтгаан жендэрийн хэвшмэл ойлголт байна. Багшийн хандлага байна, эрэгтэй багш нар байхгүй байна. Сүм хийдэд.../минут дуусав./

Б.Найдалаа: Нэмэлт минут Баасанжаргал гишүүнд.

Х.Баасанжаргал: Сүм хийдэд хөвгүүд шавилан суугаад байна. Хамгийн сонирхолтой нь энэ орчны том нөлөө нь хэн бэ гэсэн чинь хэвлэл мэдээллийн байгууллага хамгийн их сөрөг нөлөө үзүүлдгийн байна гэдэг нь судалгаагаар гараад ирсэн байна.

Тэгэхээр ингээд салбар дундын хамтын уялдааны талаар бүгдээрээ ярих цаг нь болсон. Аль нэг яам, аль нэг агентлагийг ч юм уу ингээд нэр заагаад угаасаа ахиц дэвшил гарахгүй. Миний дараагийн санал юу вэ гэвэл дарга аа Байнгын хорооны даргад ийм 2 Байнгын хороо яах гэж хамтарч хуралдаж байгаа вэ гэвэл хууль зүйн бодлого нь, хэрэгжилтийн бодлого нь хоорондоо яаж уялдах вэ гэдгийг л харах гэж бид нар энэ 2 Байнгын хороо хамтарч хуралдаж байгаа гэж ойлгоод байгаа.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлаас яг энэ жендэртэй холбоотой гарсан тогтоолуудын хэрэгжилтийг бид нар үнэлгээ хийснийг хармаар байна дараагийн хуралдаан дээрээ. Тэгээд энэ удаагийн хурлын дараа тайлан сонсоод өнгөрөх биш энэ тайлантай холбоотой өмнөх тогтоолуудын хэрэгжилттэй уялдуулаад 2 Байнгын хорооноос хамтарсан тогтоол гаргамаар байна. Чиглэл өгмөөр байна гэсэн үг тээ? Энэ дээр бид нар анхаарах ёстой байх аа.

Нэмээд 1 минутаа дарга авчихъя 3 дахь.

Б.Найдалаа: Баасанжаргал гишүүнд нэмээд минут.

Х.Баасанжаргал: Жишээ нь би нэг ийм одоо хамгийн энгийн жишээ хэлэх гэж, тайлбарлах гэж оролдоод үзье л дээ. Энд Хууль зүйн яамны Мягмар дарга байна. Би бол одоо Хууль зүйн яам байгаад баяртай байна. Ганц бие малчдын асуудал яагаад үүсээд байгаа вэ гэвэл дотуур байр хангалттай асран хамгаалалт хийж чадахгүй байгаа учраас ээж нар өнөөдөр хүүхдүүдээ харах гээд сум руу очиж байгаа, аймаг руу очиж байгаа. Бүгдээрээ мэдэж байгаа тээ? Тэгээд яагаад дотуур байрны асуудлаа сайжруулах талаар энд бид нар ярихгүй байгаа юм. Дотуур байрны асран хамгаалал сайжирч байж тэнд хүүхэд яг гэртээ байгаа юм шиг байж байж байж ганц бие малчдын асуудал шийдэгдэнэ. Бид нар ингэж уялдуулж хармаар байна гэсэн үг. Тэгэхээр ийм уялдаатай байж байж энэ бодлого өөрөө ахиц дэвшил гаргана. Тэгэхээр энийгээ бид нар бас анхаармаар байна.

Хамгийн сүүлийн нэг асуулт жендэрийн хариуцлагатай төсөвлөлтийн талаар энд ерөөсөө огт дурдагдахгүй байна. Тайлан дээр ч бас байхгүй байна. Төсөвт бид

нар жендэрийн хариуцлагатай төсөв мөн үү үгүй юу гэдэг дүн шинжилгээ тогтмол хийж чадаж байгаа юу? Чадахгүй чадахгүй байгаа юу? Ямар шалтгаан байгаа вэ?

Б.Найдалаа: Хариулт Жендэрийн үндэсний хороо. Микрофон 3.

Г.Золбоо: Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Золбоо. Гишүүний асуултад хариулъя. Би энэ дээр бол жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаар, явцын талаар танд хариулт хэлэх гэж байна. Тэгэхлээр жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн ажлын хэсэг Сангийн ийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг 2022 онд байгуулагдаад ажиллаж байгаа. Бид нар эхлээд 2 салбар яаман дээр 2 хөтөлбөрийг аваад энэ дээр бид нар жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлалыг хэрэгжүүлж болох уу үгүй юу гэдэг туршилт хийсэн.

Тэгэхлээр бид нар энэ 2 жилийн хугацаанд юу хийсэн бэ гэхлээр ерөнхийдөө бид нарын төсөвлөж байгаа төлөвлөлт энэ бол шинэ нэмэлт төсөв гаргана гэсэн үг биш. Тухайн хөтөлбөр өөрөө ямар үр дүнтэй байсан юм бэ, жендэрийн ял ялгаатай байдлыг тусгаж чадсан юм уу, үр дүн гаргасан юм уу гэдэг дээр нь судалгаа хийгээд аргачлалыг нь тодорхой болгоё гэсэн.

Гэтэл яах вэ бид нар нөгөө манай төсөв өөрөө уламжлалт арга зүйтэй төсөвлөгддөг. Тухайн жишээлбэл багшийн ажилласан цагаар байдаг болохоос биш яг үр дүн дээр нь, гүйцэтгэл дээр нь үндэслэгддэггүй байдал нь өөрөө жендэрийн энэ ялгаатай байдлыг тусгаж байна уу манай төсөвлөлт зөв байна уу гэдгийг үр дүнг нь хэмжихэд их хэцүү байна.

Тэгэхлээр манай сан Сангийн яаман дээр бид нарын хийх гэж байгаа асуудал бол одоо бүх одоо салбар бүрийн хөтөлбөрийг хөтөлбөрт суурилсан буюу Ки Пи Ай-тай болгож, энийгээ төсөвтэй нь уялдуулж байж бид нар энийг ерөнхийдөө том зургаар нь гаргаж ирэх юм байна гэдэг ажлыг Сангийн яаман дээр манлайлал болгоод хэрэгжүүлж эхэлж байна.

Гэхдээ энэ хооронд бид нар юм хийгээгүй гэж суугаагүй. Одоо жишээлбэл төрийн албан хаагч нарт жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдгийг одоо өөрсдийнхөө бодлого, шийдвэртэй дээрээс нь төсөвтөө яаж хардаг байх вэ гэдэг гарын авлагыг бол олон улсын байгууллагуудтай хамтраад боловсруулаад явж байгаа. Түүнчлэн ерөнхийдөө цахим сургалтуудыг хийж байгаа. Тэгэхлээр бүх салбар дээр байгаа жендерийн, зөвхөн жендэрийн гэхгүй бодлого боловсруулж байгаа төрийн албан хаагч нар өөрсдөө орж ирсэн хуулийн төсөл, хөтөлбөрүүд дээрээ жендэрийн ялгаатай байдлыг хөндөж байсан байна уу, энийг бид нар харах уу гэдэг дээрээ яаж гарын авлагаа яаж хийх вэ гэдэг гарын авлагуудыг боловсруулаад ингээд энэ ажлыг хийгээд явж байгаа.

Тэгэхлээр ер нь жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг бол бид нар аль аль талдаа ойлгож байгаа. Нэмэлт төсвийн асуудал ерөөсөө биш одоо бид нарын хийсэн байгаа төсөвлөлт өөрөө үр дүнтэй байна уу гэдгийг л одоо гаргаж ирэх гээд байгаа. Тэгэхлээр энэ ажил бол Сангийн яаман дээр манлайллаар нь хэрэгжээд явж байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Микрофон 2.

А.Адилбиш: Баярлалаа. Баасанжаргал гишүүн ер нь өнөөдөр яг энэ 2 Байнгын хорооны хамтарсан хурал дээр яригдаж байгаа асуудлууд дээр үнэхээр чухал асуудлуудыг л бид нар яриад байна. Яг үнэн. Тэгэхээр салбар дундын уялдаа холбоо өнөөдрийн энэ жөндөр ордоггүй салбар гэж ерөөсөө байхгүй. Бүх зүйл жөндөртэй л холбогдож байгаа. Энэ жөндөр гэдэг чинь өөрөө уг суурь нь түрүүн Сайнзориг гишүүн хэлсэн хүн ам зүйн Монгол Улсын чухал бодлого чинь эрэгтэй, эмэгтэй хүний энэ хүйсийн тэнцвэр яагаад бүх салбар дээр хэрэгтэй байгаа юм бэ гэдэг чинь л энэ өөрөө суурь асуудал нь болоод байгаа.

Тэгэхээр салбар дундын уялдааг хэрхэн хангаж байгаа юм бэ гэхээр эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах арга хэмжээний төлөвлөгөө, жөндөрийн стратегийн төлөвлөгөө гээд энэ бүх бодлогын баримт бичгүүд маань 10 жилийн хугацаатай, 3 жилийн хугацаатай бүгдээрээ ингээд зузаан зузаан номоороо бэлэн болчихсон байгаа энэ 2031 он хүртэл 10 жилийн хугацаатай. Хамгийн гол нь энэ дээр аль яам, аль газар, аль дарга нь хариуцах юм бэ гэдгийг бүгдийг нь тусгаад өгчихсөн. Энийгээ л одоо салбарын яамнууд маань хамгийн гол нь хэрэгжүүлэх нь чухал болоод байгаа ерөөсөө. Энэ зүйлийг бас хэлье.

Мөн төсөвлөлттэй холбоотой зүйлийг Баасанжаргал гишүүн одоо асууж байна. Тэгэхлээр ер нь сүүлийн 2-3 жилийн хугацаанд энэ жөндөрийн мэдрэмжтэй, жөндөрийн хариуцлагатай төсөвлөлтийн тухай асуудлуудыг бид нар ингээд ярьж эхэлсэн. Энэ өөрөө шинэ ойлголт. Хамгийн сүүлд Канадын Мерит төслийн шугамаар энэ онд 5 аймгийн одоо Жөндөрийн хариуцлагатай төсөвлөлт Удирдлагын академийн Отгонтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Отгонтуяа боловсруулсан байдлаар Жөндөрийн хариуцлагатай төсөвлөлтийн шинэ гарын авлага бий болчихсон.

Магадгүй миний хүлээж байгаа үр дүн бол энэ жил 2026 оны төсвийг батлахдаа Улсын Их Хурал үр дүнд суурилсан төсвийг нэлээн сайн ойлгож ярьсан. Ирэх жил Улсын Их Хурлын төсөв батлах чуулган дээр жөндөрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тухай асуудлыг ярих байх гэж би итгэж байгаа.

Яагаад гэвэл олон улсын практик, туршлага нь өөрөө энэ жөндөрийн мэдрэмжтэй, энэ жөндөрийн хариуцлагатай төсөвлөлтийг хийгээд өгчихөөр энэ өөрөө хамгийн сайн төсөв болдог юм байна. Эмэгтэйчүүд рүү төсвийг чиглүүлээд байгаадаа ерөөсөө биш. Тэр төсвийг хийхдээ бүх түвшиндээ илүү эмэгтэйчүүд рүү хандсан төсвөө хийчихээр тэр нь өөрөө тухайн гэр бүлийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хүүхдийн сурч боловсрох гээд олон асуудлыг нь цаад агуулгаараа шийдчихдэг учраас энэ жөндөрийн хариуцлагатай, жөндөрийн мэдрэмжтэй төсөвлөлт өөрөө аягүй чухал байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг парламентад байгаа Улсын Их Хурлын гишүүддээ маш сайн ойлгуулахад бүх шатын төсөв боловсруулж байгаа, төсвийг баталж шийдэж байгаа энэ хүмүүст ойлгуулахад ирэх 2026 онд нэлээн сайн ажиллана гэж бодож байна.

Б.Найдалаа: Та микрофондоо өөрийнхөө нэр, албан тушаалаа хэлээдхээрэй. Тэмдэглэл тусгаж байгаа болохоор танигдахгүй.

А.Адилбиш: Жөндөрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга. Би ажлаа аваад 2 сар гаруй болж байгаа. Тийм учраас ингээд 2026 оноос илүү сайн ажиллана гээд тодотгоод яриад байгаа шүү.

Б.Найдалаа: Баярлалаа. Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Тэгэхээр тайлангаас харахад шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо дээшилсэн. Ер нь боловсрол эзэмших эрх нь бас нэлээн сайн хангагдаж байгаа. Тэр тусмаа дээд боловсрол эзэмшихэд эмэгтэйчүүд нь эрчүүдээсээ илүү түлхүү байгаа гэсэн ийм сайхан үр дүнгүүд харагдаж байна л даа.

Тэгээд шийдвэр гаргах түвшинд, ялангуяа хууль тогтоох түвшинд, дээр нь төрийн захиргааны төв байгууллагын удирдах албан тушаалд өөрөөр хэлэх юм бол яам, агентлагийн удирдах албан тушаалтнуудын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хэмжээ бас өсөн нэмэгдэж байгаа гэсэн ийм үр дүн харагдаж байна. Гэхдээ аймаг, орон нутгийн хувьд энэ арай өөр дүн харагдаад явж байх шиг байна.

Энэ 2 үзүүлэлт дээр бас боломжийн сайхан юм харагдаж байна. Ингээд жаахан цаашаа харах юм бол хөдөлмөрлөх эрхийн тухай дээр тухайлах юм бол хэдийгээр өндөр боловсролтой байгаа ч гэсэн яг ажил, хөдөлмөр эрхлэх байдал нь эмэгтэйчүүдийнх арай жаахан бага байна, авч байгаа цалин хөлс нь эрчүүдийнхээс 25 хувиар доогуур байна гэсэн ийм зүйл гарч ирж байна л даа. Энэ ерөнхийдөө их яригдаад байдаг зүйл. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай дээр зээл олгох ч байдаг юм уу, их хөдөлмөрт зуучлах ч байдаг юм уу олон янзын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа гэсэн зүйл байна.

Тэгэхээр энэ дээр би нэг зүйл хэлэх гээд байгаа нь юу вэ гэхээр Хөдөлмөрийн хуул. Хөдөлмөрийн хуульд чинь ер нь хөдөлмөрийг ажлыг илүү уян хатан зохион байгуулалттай болгох, ажлын цагийг нь уян хатан болгох, гэрээсээ ажилладаг, байршлын хувьд уян хатан болгох гээд ийм зохицуулалтуудыг хийх ийм боломжууд нээгдсэн байгаа Хөдөлмөрийн хуулиар.

Тэгэхээр төрийн болоод бизнесийн байгууллагууд яг бага насны хүүхэдтэй ээжүүд, хүүхдээ төрүүлээд, өсгөөд, хүмүүжүүлэнгээ ажил, хөдөлмөр эрхэлчих ийм боломжийг нь түлхүү нээж өгөх, энэ рүү нь илүү түлхүү чиглүүлэх тал руу үйл ажиллагаагаа чиглүүлбэл яасан юм бэ? Энэ дээр анхаараасай гэж хэлмээр байна.

2 дугаарт нь энэ танай тайлан дээрээс харахад хөдөө орон нутаг дахь эмэгтэйчүүдийн жендэрийн асуудал хамгийн бага үнэлгээ авсан байна даа 30 хувьтай. Тэнд ердөөсөө өрх толгойлсон эмэгтэйчүүд их олон болоод байна гээд л тэгж байна. Тэгэхээр энэ жендэрийн тухай асуудлыг ярихдаа бид нар зөвхөн Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хүрээнд ярихаасаа илүүтэйгээр бусад хуулиудтай нь уялдуулж авч үзвэл яасан юм. Өөрийн эрхгүй энэ хууль, эрх зүй чинь бид нарын амьдрал ямар байх вэ гэдгийг чиглүүлж байдаг зүйл шүү дээ.

Тэгээд энэ дээр би Боловсролын хуультай холбогдуулж хэлэх гэж байна. 2008 оноос авхуулаад манайх ЕБС-д 6 настайгаас нь эхлээд хүүхдийг элсүүлдэг болсон. Одоо бид нар Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын хуулиараа 5 настай хүүхдүүдийг сургуульд бэлтгэнэ гээд бас цэцэрлэгт сургаж байгаа. Ингэнгүүт хөдөө орон нутгаас ээжүүд нь хүүхдүүдээ аваад сумын төв дээр ирээд суучихдаг. Аав нь хөдөө мал дээрээ ганцаараа хоцордог.

Тэгэхээр энэ хөдөөд гэр бүл салалт, өрх толгойлсон эмэгтэйчүүд олон болоод байх тухай асуудал, эхнэргүй эрчүүд олон болоод байх тухай асуудал чинь

эргээд магадгүй бусад хуулиас тухайлах юм бол энэ Боловсролын ерөнхий хууль болоод сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн чинь зохицуулалтаас үүдэлтэй байгаад байгаа юм биш үү?

Б.Найдалаа: Хэрлэн гишүүнд 1 минутыг нэмж өгье.

Б.Хэрлэн: Тэр залуу эрэгтэй, эмэгтэй хүн эцэг, эх байх эрхээ эдлэнгээ энэ нийгмийн амьдралд бас идэвхтэй оролцох ёстой тэр хүмүүс. Тэгэхээр энэ нийгмийн суурь, үндэс болсон гэр бүлийг дэмжих энэ хуулиа боловсруулаад өргөн барьсан гээд энэ тайлангийн 18 дугаар хуудсан дээр биччихсэн байна л даа. Тэгэхээр энэ жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай ажлынхаа энэ 4 том зорилт дотроо гэр бүлийг дэмжих энэ хуулиа оруулж ирэх тухай асуудлыг тусгавал яасан юм бэ?

Ер нь энэ хүн ам зүйн бодлогоо бид нар эргэж харж зөвхөн юу гэдэг юм жендэрийн тэгш байдал эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо гэж ярихаасаа илүүтэйгээр тэр эрэгтэй нь ч бай, эмэгтэй нь ч бай гэр бүлдээ эрх тэгш, аз жаргалтай амьдрах тухай дээр нь бид нар авч үзэж энэ бодлогыг ер нь харвал яасан юм гэж хэлмээр байна.

Б.Найдалаа: Хариулт. Үг хэллээ. Баярлалаа

Надад 2 асуулт байна. Энэ жендэрийн бодлого, ер нь жендэрийн асуудал чинь нийгмийнхээ соёлынхоо талаас үзэх юм бол Монгол Улс бусад улсаас өөр шүү дээ. Өөр биз? Шал өөр. Европоос, Оросоос, Хятадаас, Япон, Солонгос, Вьетнамаас өөр. Энэ дээр жендэрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тэр соёлын, Монголын онцлогийг яаж тусгаж байгаа вэ? Ялгаа байна уу? Нэг.

Хоёр дахь нь ингээд хууль хэрэгжээд явж байна. Тал талдаа бодлого гаргаад явж байна. Яг асуудал нь яг юу байгаа юм, юу нь болохгүй байна гэдгийг дугаарлаад хэлж өгөөч гээд ийм 2 асуулт байна.

Хэн хариулах вэ? Микрофон 2.

А.Адилбиш: Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой яг энэ бидний гаргачхаад байгаа энэ 10 жилийн стратеги төлөвлөгөө байгаа юм л даа. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах 10 жил хугацаатай салбар дундын стратеги төлөвлөгөө. Бүх яамнуудад хамаатай. Тэгэхээр энэ салбар дундын стратеги төлөвлөгөө дээр таны яг сая хэлж байгаа энэ жендэрийн хэвшмэл ойлголттой Монголчуудын яг энэ соёл, түүх, уламжлалтай холбоотой энэ хандлага энэ ойлголтыг өөрчлөх дээр чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөлтүүдийг бүх салбарын яамнуудыг хамааруулаад энэ төлөвлөгөөгөө боловсруулаад гаргачихсан байгаа. Энэ төлөвлөгөө эхнээсээ хэрэгжээд явж байгаа.

Ер нь аливаа улс, үндэстний түүх, соёл энэ соёлын хандлага, төлөвшлийг өөрчлөхөд маш их хугацаа зарцуулагдана. Одоо ч гэсэн хөдөө, орон нутагт аймгийн ИТХ дээр очоод жендэрийн хариуцлагатай төсөвлөлттэй ярихаар 5 удаа аймгийнхаа ИТХ-д сонгогдсон мөртөө одоо ч гэсэн Жендэрийн хорооноос асуудаг асуулт нь 1 айлд 6 эмэгтэй хүүхэд төрчихвөл яаж тэр айлын жендэрийн асуудлыг чи шийдэх гэж байна гэж асуудаг иргэдийн хурлын дарга, төлөөлөгч өнөөдөр хэвээрээ л байгаа. Тэгэхлээр энэ ер нь энэ Монголын энэ түүх, соёл, уламжлал хандлагатай холбоотой, энэ төлөвшил ойлголттой холбоотой асуудлыг өөрчлөхөд

цаг хугацаа орно. Харьцангуй Монгол Улсын хувьд яг энэ жендэрийн хэвшмэл ойлголт маань засагдаад зөв ойлгогдоод явж байгаа гэж бидний зүгээс харж байгаа даргаа.

2 дахь асуулт нь?

Б.Найдалаа: Асуудал юу байна? Яг юу нь болохгүй байна гэсэн асуулт.

А.Адилбиш: Хуулийн хэрэгжилт тийм ээ? Хуулийн хэрэгжилттэй холбоотой. Үнэн өнөөдөр яригдаж байгаа асуудлууд бүгдээрээ яг л бодитой зүйлийг бид нар харж ярьж байна. Хуулийн хэрэгжилт сул байгаа. Энэ яагаад хуулийн хэрэгжилт сул байгаа вэ гэхээр нөгөө л сая Баасанжаргал гишүүн ярьсан энэ салбар дундын уялдаа холбоог л бид нар хангаж ажиллах ёстой. Салбар дундын ажиллагаа сул байгаа. Мөн хариуцлага түрүүн миний ярьсан. Яагаад гэвэл Сандаг-Очир гишүүн асуусан шүү дээ яагаад энэ хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхгүй байна л гээд асуусан. Тэгэхээр эргээгээд хариуцлагын тогтолцоо нь байхгүй учраас хууль хэрэгжүүлэхгүй ингээд л яваад л байж болдог ийм л жишиг байгаад байгаа юм.

Б.Найдалаа: Би түрүүний эхний асуулт дээр ийм байсан юм. Бас хандлага нь, санаа нь бол тэр хэвшмэл ойлголт хаа сайгүй адилхан шүү дээ. Америкт ч, Японд ч ерөнхийдөө адилхан байгаа жендэрийн. Тэгээд Монгол адилхан байгаад байгаа байхгүй юу. Харин зүгээр Монголын соёлын хувьд эрэгтэйчүүдийг үзэх, эмэгтэйчүүдийг үзэх аж ахуйд нь оролцож байгаа байдал нь арай өөр санагдаад байгаа юм. Тэгэхээр өөр юм бол бодлого нь өөр байх ёстой шүү дээ. Хэрвээ бид нар яг Европт явж байгаа, Америкт явж байгаа бодлогыг аваад хэрэгжүүлчих юм бол буруу шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар үнэхээр соёлын хувьд өөр юм бол, эмэгтэйчүүдийг үзэх нь өөр юм бол бодлого дээр яг юу өөр байгаа юм бэ? Хэвшмэл ойлголт яриагүй шүү. Одоо энийг мэдэх юм бол бодлого оновчтой, хэрэгжилт үр дүнтэй байна л гэж ойлгож байна.

Микрофон 3.

Б.Долгор: Жендэрийн үндэсний шинжээч Долгор байна. Ерөнхийдөө бол үнэхээр Монголчууд бол эрт дээр үеэсээ бол жендэрийн асар өндөр, мэдрэмжтэй хандлагатай ийм түүхтэй. Тэгэхдээ энэ байдлаа сүүлийн үед алдсан. Ер нь бол Монголчууд эрэгтэй, эмэгтэйчүүд бас тодорхой хэмжээний тус тусын үүрэгтэй, гэрийн 2 багана болж явах жишээтэй. Одоо яг улс орныг удирдахын тухайд бол мөн одоо ялгаа байхгүй. Хаан хүн ч гэлээ гэсэн хатан буюу ээжтэйгээ зөвлөж шийдвэр гаргаж байсан ийм агуу суу ухаан, уламжлалтай. Үүнийг бид бүхэн арга, билгийн хос ёс гэж үүнийг дээдэлж ирсэн ийм ард түмэн байдаг.

Тэр ч үүднээсээ яг хаан ухаан, хатан ухаан гээд тухайн үедээ бол.../минут дуусав./

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Микрофон 3.

Б.Долгор: Улс орныхоо удирдлагын түвшиндээ хэрэгжүүлж ирсэн байдаг л даа. Тэгэхээр яг энэ уламжлалаа бид нар илүү сэргээх тал руугаа манай жендэрийн бодлого явах ёстой гэдэг утгаараа бол явж байгаа. Нэгэнт нөгөө алдагдчихсан бодлогыг бас сэргээхийн тулд тодорхой хэмжээгээр бас бусад улс орнуудын туршлагыг ч гэсэн бид авахаас аргагүй байгаа.

Тэгэхээр хамгийн гол нь юу вэ гэхлээр бид тэр жендэрийн хэвшмэл үзэл гээд байгаа тэр дотор байгаа зүйлсийг өөрчлөхдөө тэр Монгол хүний бас генд нь оршиж байгаа энэ одоо зөв соёл, уламжлалаа сэргээх утгаар нь ингэж одоо явах ёстой гэдэг ийм зарчмаар явж байгаа. Энэ дотор байж байгаа нэг чухал манай бодлого юу байна вэ гэхлээр Жендэрийн хуульд тусгачихсан байгаа тусгай арга хэмжээ гэж. Өөрөөр хэлэх юм бол ялгаатай байгаа зүйл дээр эрэгтэй дээр.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ дээр үнэхээр Монгол ялгаатай юм бол ялгаатай гэдгээ тов тодорхой мэддэг тэрэнд нь сууриалаад бид нар иймэрхүү ялгаатай бодлого явуулж байгаа гэдэг байр суурьтай байвал үр дүн талаасаа ч, ойлгуулах, мэдээлэх талаасаа ч, хүлээн зөвшөөрөх талаасаа ч илүү зөв гэж бодож байна. Та бүхэн энэ дээр анхаараарай.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тайлантай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Рэгдэл гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Энэ ер нь бол Монголчууд бол одоо яг Ази тивдээ бас энэ жендэрийн эрх тэгш байдлын асуудлаар бол харьцангуй одоо дэвшилттэй байдаг болов уу гэж би зүгээр хувь хүний хувьд боддог юм. Энэ жендэрийн эрх тэгш байдлын тухай энэ ойлголт ерөнхийдөө нийгмийн түвшиндээ хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь, ойлголт энэ соёл нь өөрөө яаж тогтож байна вэ гэдэг нь илүү хамгийн чухал юм болов уу гэж бодоод байгаа юм л даа. Тийм учраас энэ болохоор одоо ингээд СӨБ, дунд сургууль, их, дээд сургуульд яг энэ жендэрийн эрх тэгш байдлыг хангах, энэний цаана ямар ойлголтууд байдаг юм гэдэг талаарх ерөнхий суурь одоо ойлголт өгөх энэ түвшний ажлууд маань л илүү чухал байх аа гэж боддог.

Тийм учраас одоо Монгол Улс маань энэ Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулиа стратегиа батлаад хэрэгжүүлж байгаа. Энэ түвшин дээрээ ер нь яг нийт хүн амын тодорхой яг энэ талын ойлголттой түвшин одоо ямар хэмжээтэй байгаа юм? Энэ та бүхний баримтлаад байгаа 10 жилийн стратегийн дараа хэд болох юм ч гэдэг юм уу яг энэ түвшнүүдийнхээ энэ хэрэгжилт, хяналтаа хийх дээрээ бас сайн анхаарах ёстой болов уу. Тэгвэл угаасаа нийгэм тэр чигээрээ тэр энэ жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт нь сайн байвал угаасаа л ажил нь сайн байна шүү дээ. Тийм учраас энэ дээр анхаарах ёстой байх аа гэж хэлмээр байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Бум-Очир гишүүн үг хэлнэ.

Д.Бум-Очир: Та бүхэнд амжилт хүсье. Тэгээд нэг зүйлийг захиж хэлмээр санагдаж байна. Түрүүн Байнгын хорооны дарга бас хэлэх гээд оролдоод байна. Бид бол энэ жендэрийн маш өөр түүх, соёлын онцлогтой ард түмэн. Бидэнд маш их давуу тал байгаа. Европт гэхэд дундад зууны үед эмэгтэйчүүдийг буюу жаахан илүү сэтгэж байгаа, илүү ярьж байгаа, тодорхой хэмжээгээр манлайлал үзүүлэх гэж байгаа гэсэн эмэгтэйчүүдээ шулам гээд шатаагаад алдсан тохиолдол байгаа шүү дээ. Тоо нь янз бүрийн тоо байдаг түүхэнд. 50-70 мянга гэж байгаа шүү дээ дундад зууны үед. Ийм түүхтэй улсууд жендерийг ярих бидэн шиг түүхтэй хүмүүс жендерийг ярих хоёр их өөр.

Бид бол эмэгтэйчүүдээ хайрлаж, хамгаалж, эмэгтэй хүнийг, эх хүнийг бүүр шүтдэг ийм уламжлалтай ард түмэн. Бүүр Монголын түүх соёлд тов тодорхой байгаа. Энийгээ олон улсад дотооддоо болоод олон улсад нэлээд их чухалчилж гоёор хэлбэл Пи Ар маягаар ашиглаасай гэж би хүсэж байгаа юм. Бид нар та нар шиг эмэгтэйчүүдийг 60, 70 мянгаар нь шулам гэж устгаж байсан түүхгүй шүү. Уучлаарай. Жендэрийн асуудал дээр түүхээ яривал, соёлынхоо онцлогийг яривал та хэд биднээс сурах зүйл ихтэй шүү гэдэг асуудлыг олон улсын хэмжээнд гаргаж тавиасай гэж би та бүхнээсээ хүсэж байгаа юм.

Исламын шашинтай зарим орнуудад ч гэсэн бид нар мэднэ шүү дээ. Тэр янз бүрийн гэр бүлийн асуудлаар эс үгүй бол энэ хүнтэй суу гэсэн тэр шийдвэрийг нь дагаагүйгээс болоод нүх ухаад эмэгтэйчүүдийг хийгээд ах дүү, хамаатан садан, авга, нагачынх нь хүмүүс нийлээд чулуугаар нүдсээр байгаад алаад тэнд нь тэгээд булшлаад орхидог. Ийм хэрцгий уламжлал Монголд байхгүй. Энийг бид нар ярих хэрэгтэй.

Жишээ нь, Европт, Германд эх орныг “fatherland” буюу эцэг орон гэж байхад бид нар эх орныг эх орон гэж эмэгтэйчүүд шиг эмэгтэй гэдэг ... нэрлэж байх гэх мэтчилний маш олон жишээнүүд байгаа. Чингис хаан эхдээ яаж хандаж байна, эхнэртээ яаж хандаж байна гэх мэтчилний маш олон зүйлийг ингээд яриад байвал бидэнд түүх соёлын баялаг уламжлал бий бөгөөд энэ нь манай хамгийн том дав овоо тал бөгөөд түүх соёлын суурь гэж бодож байна. Та бүхэн бас сая асуултдаа хариулахдаа хэлж байна. Энэ онцлогоо бид нар гаргаж сэргээх хэрэгтэй байна гэж.

Тэгэхээр энийгээ бид нар олон улсад ярьж бидэнд байгаа бас маш чухал онцлог гэдгийг таниулж явах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Нэг дүгээр зүйл.

Дараагийн зүйл юу гэхээр түрүүн зөндөө яриад байна. Энэ түүх соёлын онцлогтой бас нэг зүйл өнөөдөр тэр хөдөөгийн малчин залуучуудад тохиолдоод байгаа эхнэр олдохгүй байгаа үйл явдал бас мөн шүү дээ. Бид нар нөгөө эмэгтэйчүүдээ хайрлаж хүндэлдэг учраас тухайн айл хотод хүүхдээ сургуульд явуулах бол охиноо явуулчихдаг, хүүгээ мал дээр аваад үлдчихдэг. Нөгөө л охиндоо хөрөнгө оруулалт хийдэг ийм агуулга бас л түүх соёлын ялгаа байгаа. Энэ талаар Соёлын яам хөдөөгийн малчин залуучуудын ахуйн асуудал, тулгамдаж байгаа асуудлаар судалгаа хийчихсэн байгаа. Саяхан дууссан байх ёстой. Та бүхэн олж үзээрэй гэдгийг захиж гэсэн юм.

Дараагийн нэг зүйл сая бас гишүүдийн ярианд давтагдаагүй нэг зүйлийг би бас онцгойлон хэлмээр байна. Яг шүүх дээр очоод ял авахад тулахад эмэгтэйчүүдэд арай зөөлөн ханддаг, эрэгтэйчүүдэд арай хатуу хандчих гээд байдаг ийм нэг зүйлийг манай энэ шүүх, хуулийн байгууллагад ажилладаг улсууд ярьдаг юм. Яг шүүх шийдвэр гаргахдаа энэ эр юм гэж, эс үгүй бол энэ эмэгтэй хүн юм гэж ялгавартай хандах тийм шүүгчийн хандлага, прокурорын хандлага байдаг. Энэ яг цаасан дээр, цагаан цаасан дээр хараар биччихсэн байгаа хууль, журмыг баримтлахад бас магадгүй эрэгтэйчүүдэд маань илүү хүнд тусаад байдаг тал байдаг байж магадгүй. Энийг та бүхэн маань судалж, анхаарч үзээсэй гэдгийг хүсмээр байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа Рэгдэл гишүүн үг хэлнэ.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тайланг сонслоо. Манай гишүүд маань бас чухал чухал асуудал асууж, хариултаа авлаа. Хариулт янз бүр байлаа. Тэгэхээр хариулт янз бүр байхаас аргагүй юм байна. Жендэрийн асуудал угаасаа нийгмийн амьдралын бүх хүрээ, эдийн засаг, улс төрийн үйл ажиллагааны бүх салбарт яах аргагүй тооцох ёстой ийм асуудал учраас энэ дээр төгс төгөлдөр юм байхад их хэцүү. Гэхдээ энэ асуудалдаа энэ жендэрийн эрх тэгш байдлыг хангах гэдгийнхээ цөм асуудлуудыг л их ялгаж авмаар юм шиг санагдлаа. Статистикийн хорооны дарга ямар ч байсан хүрээгээ 141 үзүүлэлтээр тодорхойлоод тэд нарыгаа тооцдог аргачлалыг баталчихсан юм байна. Энэ чухам аль хэр оновчтой болж вэ? Энэ бүхнийг авч үзэхгүй бол жендэрийн асуудал гээд бүх асуудлыг оруулж ирээд байвал энэ жаахан бүтэл муутай ийм зүйл болох талтай.

Жишээлбэл би хэлье. Энэ оюутан суралцагчид дунд оюутнууд дунд 30 гаруй хувь нь эрэгтэйчүүд байдаг. Энэ сүүлийн 20-иод жил явж байгаа үзүүлэлт. Тэгэхээр энэ үеэс эхлээд дээд боловсролтой боловсон хүчний 70 орчим хувь нь эмэгтэйчүүд болоод одоо тэд нар маань нийгэм, улс төрийн амьдрал үед хүчтэй ордог 40 орчим насан дээрээ ороод явж байгаа улсууд байгаа.

Тэгэхээр цаашдаа энэ явдал энэ чигээрээ ингээд яваад байвал энэ удирдах түвшний дунд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, тоо хэмжээ аяндаа нэмэгдээд явчих ийм тал бий.

Нөгөө талаас бид нар энэ дунд сургуулийн хүүхдүүдийн асуудлыг сая нэлээн ярилаа. Энэ гэр бүл салалттай ч холбож ярьж байна. Өөр олон асуудалтай. Тэгэхээр энд гол асуудлаа бид нар шийдэхгүй бас 20-иод жил явж байгаа юм. Энэ гол асуудал бол хөдөөгийн малчин айлын хүүхдийг 7 настайгаас нь сургуульд оруулах асуудал. Ерөөсөө энийг шийдчих юм бол тэр дотуур байрны асуудал энэ тэр чинь аяндаа шийдэгдээд явна. Тэр хүүхэд сургуулиас завсардах асуудалд ч нөлөөлнө энэ бол. Ер нь хөдөөгийн малчдын асуудал саналыг та нар бас их сайн сонсвол зүгээр. 4 дүгээр ангиас хойш, ангиас малчин болоод гарахаар хүүхэд угаасаа малчин болж чаддаггүй юм гэж манай хөдөөгийн малчид ярьдаг. Малаасаа хөндийрчихдөг, сэтгэлээсээ малчин хийж чаддаггүй гэж.

Тэгэхээр зэрэг энэ малчдын залуу халааг яаж бэлдэх вэ гэдэг өөр бодлого хэрэгтэй байна гэдэг нь энд харагдаад байгаа юм. Энийг ямар ч байсан энэ 7 наснаас нь сургуульд ордог юмыг шийдээд өгчих юм бол бас нэлээн хэдэн асуудлыг шийдэж болно.

Нөгөө энэ жендэр дээр ярьж байгаа асуудал бол энэ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүгийн асуудал. Энийг бодлогоор шийдэхэд их хэцүү. Энэ цаанаасаа генээрээ зохицуулагдсан ийм асуудал байгаад байгаа юм.

Яагаад вэ гэвэл дэлхий даяар эмэгтэйчүүд нь урт насалдаг. Манайд зүгээр зөрүү нь л өндөр байгаа. Хүүхэд анх төрөхөд 51 хувь нь эрэгтэй хүүхэд төрдөг. 49 хувь нь эмэгтэй хүүхэд төрдөг. Ингээд 5, 6 насандаа хүрээд ирэхийн үед хүйсийн харьцаа сая тэнцэж ирнэ. Өөрөөр хэлбэл, энэ бага насандаа эрэгтэй хүүхдүүдийн эндэгдэл маш өндөр байна гэсэн үг. Энийг бууруулж чадвал бид нар энэ насны зөрүүг, насжилтын зөрүүг багасгах үндэстэй. Ингээд нас ахиад явахаар би сая нас статистик харлаа. Одоо миний насныхан дунд эрэгтэйчүүд нь 30 хувь, эмэгтэйчүүд нь 60 хувь, 60 гаруй хувьтай л байна. Тэгэхээр ингээд нас ахих тусам эрэгтэйчүүд богино насалдаг нь энэ ген, генетик үндсээр нь шийдэж өгөхгүй бол тэр хар хүнд

ажил хийдэг, архи уудаг, тамхи татдаг гэдэг гол хүчин зүйл нь биш гэдэг дээр бас анхаарч ажиллавал их сайн байна.

Тэгээд энэ үйл ажиллагааныхаа тайланг ингэж гаргаад танилцуулаад энэнийхээ дагуу дараа дараагийнхаа үйл ажиллагаанд шинэчлэл хийгээд явбал энэ жендэрийн асуудлаа шийд.../минут дуусав./

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ саяын асуудалтай холбоотой би бас үг хэлье.

1 дүгээрт тэр сая гишүүд бас ярьж байна. Бид нар бусад улсаас ялгаатай. Ялгаатай юм бол ялгаатай бодлого гаргаж байж ялгаатай байдал нь, мэдээлэл нь, ойлголт нь илүү нийгэмд хүрнэ.

Тийм болохоор нөгөө бусдаас хуулсан маягтай ингэдэг юм байна лээ гэсэн маягтай, төсөл хэрэгжүүлэгчийн маягтай арга барилаасаа жоохон гармаар санагдаад байдаг жендэрийн асуудал дээр. Монголын соёл яг бид нар чинь нээрээ эмэгтэй, эрэгтэй хүмүүсээ юу гэж үздэг билээ гэдгээ судлаад энэ нь ийм болохоор ингэх юм байна, энэ мэдээллээ ингэж өгөх юм байна энийг яг Монголд Улсад хэрэгжүүлж байгаа бодлогодоо тусгамаар байгаа юм энэ дээр онцгойлон. Тэгээд энийгээ бүүр дурддаг болмоор байгаа юм. Бусдаас ялгардаг болмоор байгаа юм

2 дахь нь яг энэ жендэрийн тайлан хэлэлцэж байгаа болохоос жендэрийн асуудал гэж байхгүй гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл цаана нь байгаа нийгмийн бүх асуудал Монгол Улсад байгаа нэг л асуудал байгаа байхгүй юу. Нийгмийн асуудал. Зүгээр жендэр гэж байгаа нь тэрийг харж байгаа олон талтын нэг өнцөг нь, нэг талст нь болохоос биш ердөөсөө жендэрийн асуудал гэсэн юм байхгүй. Зүгээр жендэр талаас нь асуудал руу орж харж байгаа л гэсэн өнцөг талаас нь хандахгүй бол жендэр гээд хууль баталчихсан тэрийгээ хэрэгжүүлчих юм бол Монголын бүх асуудлыг холбогчлоод больчих юм шиг. Ингэх юм бол бид нар өөрсдийгөө бас хуурсан болно. Энэ талаас нь бас Жендэрийн үндэсний хороо болон тайлан тавихдаа ч, асуудалд хандахдаа ч гэсэн хандвал түрүүний ярьж байгаа тэр салбар хоорондын харилцааг үүсгэхэд хамтарч ажиллахад илүү хэрэгтэй болох юм болов уу.

Жишээлбэл тэр юуны асуудал байна шүү дээ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн насны асуудал байна, насжилтын асуудал байна. Их бага байна гээд ярьж байна. Эрүүл мэндийн асуудал болон залуу гэр бүлийн асуудал орон нутагт байгаа, хөдөө орон нутагт болж байгаа тэр тэнцвэр алдагдаж байгаа асуудал 2 адилхан юм шиг боловч эрс тэс ялгаатай ач холбогдлуудын шал өөр асуудал. Нэг нь яг сайн ярих юм бол хувийн дадал, зуршил. Сая бас Рэгдэл гуай хэлж байна биологийн юмтай ч холбоотой явж таарах гээд байгаа юм.

Тэгэхээр тэр хүнээс хамаарч байгаа асуудал бодлогоос биш нөгөөх нь бид нарын яг жинхэнээсээ Монгол төрийн бодлогоос хамаараад нийгмийн хүйсийн, залуу гэр бүлийн хооронд тэр хүйсийн тэнцэл алдагдаж байгаа бол ноцтой асуудал. Тэгэхээр энэ бодлогоос Засгийн газраас энд сууж байгаа хүмүүсээс хамаарах зүйл болохоор ялгаж салгаж үзэхгүй бол хооронд нь холиод зөвхөн тэр эрчүүдийн наслалтын зөрүүг арилгая гээд явах юм бол бид нар эрэмбийн асуудалд том алдаа хийнэ гэж бодож байна.

Тэгэхээр энэ дээрээ асуудал эрэмбэлэхдээ энийг харгалзвал яасан юм бэ гээд тэгээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал дээр явж байгаа тэр бодлогын

асуудлууд бол жендэр гэхээсээ илүү өөр хаягтайгаар яг жендэрийн асуудал байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ өнцгөөс нь хандвал зөв санагдаад байна.

Манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос бид нар угаасаа яг энэ асуудлыг ээлж дараадаа хэлэлцээд явж байгаа.

Жишээлбэл, амиа хорлолтын асуудлыг хэлэлцсэн. Тэр бол эрүүл мэндийн асуудал ердөөсөө биш. Спортын асуудал, соёлын асуудал, боловсролын асуудал, цаашлах юм бол шинжлэх ухааны асуудал байгаад байдаг. Энийг ингээд нэгтгээд Байнгын хороо юуны тулд асуудлаа нэгтгэдэг билээ нэгтгээд явах тийм төлөвлөгөө, зорилгын дагуу бид нар ажиллаж байгаа.

Бас нэг чухал зүйл ингээд жендэрийн асуудал гээд өнөөдөр ч гэсэндээ гарч байна. Жендэр жендэр гээд яриад байдаг. Яг үнэндээ бид нар түрүүний хэлдэг залуу гэр бүлийн хүйсийн тэнцвэрийн асуудлыг, нийгмийн асуудлуудыг нөгөө талаас нь үзэхгүйгээр хаячхаад албан тушаал яриад байгаа байхгүй юу. Жендэр гэхээр албан тушаал ярьдаг болчихоод байна шүү дээ яг сүүлдээ. Зөв юм шиг боловч хамгийн ач холбогдол багатай тэр доод асуудлаа шийдчих юм бол дээшээ аяндаа нөөц нь бэлтгэгдээд шийдэгдчих газар хүний нөөц нь бэлтгэгдээгүй ч юм уу, нийгэм нь өөрөө бэлэн биш байж байж жендэр дээрээ, албан тушаал дээрээ тэдэн хувь эдэн хувь гээд бие биеийгээ шахдаг иймэрхүү муйхар үр дүн багатай арга руу төвлөрөөд тэгээд жендэрийн асуудал нь өөрөө ийм юм шиг нийгэмд тусаад үр дүнгүй болох гээд байна.

Тэгэхээр энийгээ Жендэрийн үндэсний хороо бас тэр фокус, тэр анхаарлаа илүү өргөн болгохгүй бол албан тушаал ярьсан хүйс хоорондын маргаан юм шиг болоод асуудлаа жижгэрүүлээд бүүр ингээд утгагүй болгоод байна. Энийгээ бараг орхиод энэ чинь угаасаа байж байх асуудал. Орхиод гол асуудал руугаа төвлөрвөл яасан юм бэ. Тухайлбал, тэр залуу гэр бүлийн тэнцвэрийн асуудал. Энийг шийдчих юм бол бид нар асар олон асуудал шийднэ. Түүнээс албан тушаалыг зөв хуваариллаа гээд бид нарын асуудал яг үнэнийг хэлэхэд богино хугацаанд юу ч шийдэгдэхгүй шүү.

Тийм болохоор энэ дээрээ анхаарч ажиллаад арай өргөн хүрээнд жендэрийн гэсэн нэртэй боловч нийгмийн асуудлыг шийдэх талаас нь Байнгын хороотой хамтраад ажиллаасай гэж хүсэж байна. Түрүүн зарим гишүүд бас Баасанжаргал гишүүн санал гаргаж байсан. Энхнасан гишүүн бас түрүүн хэлээд явсан энэ дээр ингээд нэгдсэн хуралдаанаар, чуулганаар хэлэлцвэл яасан юм хэн бэ гээд. Тэр одоо бол Байнгын хороогоор ингээд хуулийнхаа дагуу 2 Байнгын хороогоор 60 гишүүн хэлэлцэж байгаа юм чинь шууд энэ асуудлаа яг үүгээр нь давтаж ярих шаардлагагүй.

Харин тодорхой шийдэл, чиглэл өгөхөөр бол тогтоолын төсөл боловсруулаад Байнгын хороо байна уу, Их Хурлын байна уу тэгээд дараагийн хаврын чуулганаар хэлэлцээд явна гэсэн бодолтой байна.

Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.8-д заасны дагуу Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан

хуралдаанаар 2 жил тутам сонсоно, хэлэлцэнэ гэж заасны дагуу тайланг хэлэлцлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөлөө.

Идэвхтэй оролцсон ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Мөн гишүүддээ баярлалаа.

13.40 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР